



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО
БОДИТООР ХЭРЭГЖИХ, ИРГЭД АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ БОЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРЫГ БИЙ БОЛГОХОД ХАМТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРЧИМ ЧУХАЛ
ХУВЬ НЭМЭР ҮЗҮҮЛЭХЭЭР БАЙНА.**

**АУДИТЫН НЭР: ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, АЖЛЫН БАЙР
НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: СБА-2025/35-ШТА-ГА

Баруун-Урт 2025 он

**Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа**

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatar@audit.gov.mn
Аудитор Э.Алтансүх
Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.... 4
БҮЛЭГ А. ХАМТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ОЙЛГОЛТЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЖ, ЖДҮ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, ДЭМЖИХЭД ТӨСВИЙН НӨӨЦ БОЛОМЖИЙГ БҮРЭН ДАЙЧИЛСНААР АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА. 5

1.1. Олон улсад үр дүнгээ өгч буй хамтын эдийн засгийн зарчим, ойлголтыг орон нутагт түгээн дэлгэрүүлж, олон гишүүнтэй хоршоолсон хуулийн этгээдийг бодлогоор дэмжсэнээр ЖДҮ, үйлчилгээ хөгжиж, ажлын байр нэмэгдэх боломжтой байна..... 5

1.2. ЖДҮ, үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд төсвийн нөөц боломжийг бүрэн дайчлаагүй байна..... 11

БҮЛЭГ Б. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД ШИНЭЭР АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА АСУУДЛЫГ ХАМТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРЧМААР ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА..... 14

2.1. Сүхбаатар аймгийн 40 аж ахуйн нэгж татварын хөнгөлөлтөд хамрагдаж, 115.9 сая төгрөгийн татварын буцаан олголт авсан бөгөөд аймгийн татвартай харьцдаг 404 аж ахуйн нэгж 2024 онд төрийн худалдан авалтын 25.8 хувийг ханган нийлүүлсэн байна..... 14

2.2. Хамтын эдийн засгийг орон нутагт төлөвшүүлж, дэмжин хөгжүүлснээр үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар олгосон газрын ашиглалт сайжирч, тээвэр-логистикийн өртөг буурч, хэрэглэгч-нийлүүлэгчийн оролцоо эзний зарчмаар бэхжиж, улмаар аймгийн дотоодын хэрэгцээг хангах чадвартай, санхүүгийн тогтвортой үйл ажиллагаа бүхий ААНБ-уудын бүтэц төлөвшин бий болох нөхцөл бүрдэнэ..... 17

2.3. ЖДҮ, үйлчилгээг дэмжих арга хэмжээнүүдийн хэрэгжилт бодит шалгуур үзүүлэлттэй уялдаагүй, тодорхой бус байсан бөгөөд зээлд хамрагдсан байгууллагуудын 69.3 хувь нь нийгмийн даатгалын бүртгэлгүй, ЖДҮХС-ын зээл олгосон ААНБ-ууд шинээр ажлын байр нэмээгүй, заримынх нь ажлын байр буурсан байна..... 23

Холбогдох байгууллагын санал:..... 30

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар: 34

ДҮГНЭЛТ: 34

ЗӨВЛӨМЖ: 35

САНАЛ: 36

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуйн
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БЭМХЭДС	Боловсрол эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ХАА	Хөдөө аж ахуй
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөгжлийн бодлогын баримт бичиг ба хуульд заасан дэмжлэгийн уялдаа	5
Хүснэгт 2	Сүхбаатар аймгийн ДНБ	9
Хүснэгт 3	Их дүнтэй бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн ААНБ-ууд	15
Хүснэгт 4	Хамтын эдийн засаг хөгжсөн улс, орнуудын сайн туршлагууд	18
Хүснэгт 5	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар олгосон газрын мэдээлэл	22
Хүснэгт 6	ЖДҮ, үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хэрэгжилт	23
Хүснэгт 7	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн мэдээлэл	25
Хүснэгт 8	Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн мэдээлэл	26
Хүснэгт 9	Хөнгөлөлтэй зээлд хамрагдагчдын татвар, НД-ын бүртгэл	27
Хүснэгт 10	ЖДҮХС-аас 2024 онд зээл авсан ААНБ-уудын бий болгосон ажлын байрны мэдээлэл	27

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	
Аудит үндэслэл, эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан "Аудитын сэдэв батлах тухай" А107, "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Сүхбаатар аймгийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч ААНБ-ууд, хэрэгцээ шаардлага, дотоодын зах зээлийн хангалт, хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Хоршоо хөгжүүлэх сан, Шинэ хоршоо хөдөлгөөн болон Хүнсний хувьсгал хөтөлбөрөөр 2024 онд авсан зээлийн ашиглалт, зориулалт, эргэн төлөлт, татвар, нийгмийн даатгалд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлт зэрэг асуудлын хүрээнд Сүхбаатар аймгийн Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын газар болон холбогдох бусад байгууллага, зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа авах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2025 оны 10 сарын 01-ны өдрөөс 12 дугаар сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ А. ХАМТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ОЙЛГОЛТЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЖ, ЖДҮ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, ДЭМЖИХЭД ТӨСВИЙН НӨӨЦ БОЛОМЖИЙГ БҮРЭН ДАЙЧИЛСНААР АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

1.1. Олон улсад үр дүнгээ өгч буй хамтын эдийн засгийн зарчим, ойлголтыг орон нутагт түгээн дэлгэрүүлж, олон гишүүнтэй хоршоолсон хуулийн этгээдийг бодлогоор дэмжсэнээр ЖДҮ, үйлчилгээ хөгжиж, ажлын байр нэмэгдэх боломжтой байна.

1.1.1. Өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад хамтын эдийн засгийн зарчим, ойлголт нь орон нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ЖДҮ, үйлчилгээг хөгжүүлэх, ажлын байр бий болгох чухал шийдэл болсон байна.

1.1.1.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ, хөгжлийн үе шат, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө, гадаад зах зээлд нэвтрэх чадамж, техник, технологийн байдлыг нь харгалзан төрөөс дараах чиглэлийн дэмжлэгийг үзүүлнэ” гэж заасан.

Хүснэгт 1. Хөгжлийн бодлогын баримт бичиг ба хуульд заасан дэмжлэгийн уялдаа

Жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээг төрөөс дэмжих чиглэлүүд	Алсын хараа 2050	Үйл ажиллагааны хөтөлбөр ¹	Үндсэн чиглэл ²	ЖДҮ хөтөлбөр ³
8.1.1.жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх;	2021–2030 үйл ажиллагааны 2.1.10, 3.3.14, 3.3.17, 4.5.7	3.8.2, 3.10.1.6	3.2.3	3-р бүлэг (Зөвлөх үйлчилгээ)
8.1.2.санхүүгийн дараах дэмжлэгийг үзүүлэх:	2021–2030 үйл ажиллагааны 3.3.20, 4.5.9	3.8.2.2	4.1.4, 4.3	2-р бүлэг (Хөрөнгө оруулалт, санхүү)
8.1.2.а.хөнгөлөлттэй зээл олгох;	2021–2030 үйл ажиллагааны 2.4.7, 3.3.18	---	---	2-р бүлэг 2.1
8.1.2.б.шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах;	---	---	---	---
8.1.2.в.зээлийн давхар батлан даалт гаргах;	2021–2030 үйл ажиллагааны 3.3.19, 4.5.10	---	---	---
8.1.2.г.зээлийн хүүгийн татаас олгох;	---	---	---	---
8.1.2.д.тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх.	---	---	---	---
8.1.3.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;	2021–2030 үйл ажиллагааны 2.4.9, 2.4.10	---	---	---
8.1.4.экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;	Алсын хараа-2050 бодлого (1-р хавсралт) 4.2, 4.5	3.8.2	4.2, 4.2.1, 4.2.4, 4.2.6, 4.2.7	1-р бүлэг (экспорт) 4-р бүлэг

¹ “Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

² “Аймгийг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”

³ “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2021-2024 онд Сүхбаатар аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

**Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж
буй бодлогын хэрэгжилт, үр дүн**

				(стандарт, инновац)
8.1.5.бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх;	2021–2030 үйл ажиллагааны 3.3.17, 3.3.18, 6.4.6	---	4.1.5	---
8.1.6.бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;	2021–2030 үйл ажиллагааны 3.3.22, 2.4.21	---	3.2.1	3-р бүлэг (Зөвлөх үйлчилгээ)
8.1.7.шинэ бүтээгдэхүүн бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих;	Алсын хараа-2050 бодлого (1-р хавсралт) 4.5	---	4.2.2, 4.2.3	4-р бүлэг (стандарт, инновац)
8.1.8.техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	2021–2030 үйл ажиллагааны 2.4.10, 4.5.8	3.8.2.4	4.2.2, 4.2.8	4-р бүлэг (стандарт, инновац)
8.1.9.кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадавх бусад онцлогоос хамааран дэмжих;	2021–2030 үйл ажиллагааны 4.5.11	---	3.2.2	2-р бүлэг 2.4
8.1.10.гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх.	2021–2030 үйл ажиллагааны 3.3.23, 4.5.8	3.10.1.5	4.2, 8.6.2	5-р бүлэг (зах зээл, борлуулалт)

1.1.1.2. Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар хуульд тусгайлан заасан 10 чиглэлээс дараах төрлийн дэмжлэгүүдийг хэрэгжүүлэх талаар хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхой тусгаж өгөөгүй байна. Тодруулбал: шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах; зээлийн хүүгийн татаас олгох; тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх гэсэн 3 төрлийн төрийн дэмжлэгийг хэрэгжүүлэх арга хэмжээ тусаагүй бөгөөд орон нутагт эдгээр дэмжлэг бодитоор хэрэгжиж эхлээгүй байна.

1.1.1.3. Манай улсад, тэр дундаа орон нутагт “**хамтын эдийн засаг**” (**cooperative economic**-хоршоолсон эдийн засаг)-ийн ач холбогдлын талаарх ойлголт харьцангуй бага байгаа ч олон улсын бодит жишээ, тоон баримтууд энэхүү хамтын эдийн засгийн загвар нь бодит эдийн засгийн том оролцогч болохыг тод харуулж байна: **World Cooperative Monitor** 2025-ын мэдээллээр дэлхийн Top 300 кооператив байгууллагын 2023 оны нийлбэр эргэлт 2,788.66 тэрбум ам.доллар хүрч, үйлдвэрлэл, өртгийн гинжин хэлхээ, үйлчилгээний бодит хэрэгцээг хамарсан ХАА ба хүнс (107 байгууллага), даатгал (95), худалдаа (54), санхүү (29) зэрэг салбаруудад хамгийн өргөн тархжээ.

1.1.1.4. Энэ хамтын эдийн засгийн систем нь зөвхөн нэг бүсэд төвлөрдөггүй бөгөөд Top 300 байгууллагын төлөөлөл Европ (161), Америк тив (103), Ази-Номхон далай (36) гэж бүсчилсэн хэмжээнд тогтвортой байр суурь эзэлж, улсуудаас АНУ (79), Франц (41), Герман (29), Япон (18), Нидерланд (16) зэрэг олон төв бүхий бүтэцтэй байгааг харуулдаг. Түүнчлэн Европын хэмжээнд кооператив банкны тогтолцоо 84 сая гишүүн, 713,000 ажилтантай бөгөөд Европын банк, орон нутгийн эдийн засгийг санхүүжүүлэх зах зээлд ~20% орчим хувийг эзэлдэг жишээ нь хамтын эдийн засаг нь “**жижиг санаачилга**” бус, тогтвортой санхүүжилт ба орон нутгийн эдийн засгийн өсөлтийг тэтгэх институтийн шийдэл болохыг нотолж байна.

1.1.1.5. Хамтын эдийн засаг (хоршоолсон эдийн засаг) нь иргэд, үйлдвэрлэгчдийн хуримтлал ба эдийн засгийн үр өгөөжийг гишүүдийн өмчлөлөөр дамжуулан орон нутагт үлдээж, нийлүүлэлтийн сүлжээ, зах зээлд нэвтрэх чадварыг нэгтгэн өрхийн орлогыг тогтворжуулах болон ажлын байрыг тогтвортой нэмэгдүүлэх бодит механизм болдог. Мөн малчин, жижиг дунд бизнес эрхлэгчдийг санхүүжилт, даатгал, худалдан авалт, борлуулалтын нэгдсэн бүтэцтэй холбосноор зардал бууруулах, чанар стандарт сайжруулах, эрсдэл хуваалцах үр нөлөөг бий болгож, тус тусдаа байхад боломжгүй байсан хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэх суурь бүрдүүлдэг. Иймд хүн ам сийрэг, зах зээл жижиг, эрсдэл өндөр орчинд хамтын эдийн засаг нь эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, бүс нутгийн хөгжлийн тэгш бус байдлыг бууруулах өндөр өгөөжтэй шийдэл юм.

1.1.1.6. Хамтын эдийн засаг буюу хэдэн зуу, мянган өрх хамтарч, хоршин хэрэглэгч ба эзэн, нийлүүлэгч ба эзний зарчмаар ажилладаг хоршоолсон хуулийн этгээдүүдийг дэмжих талаар манай улсын болон аймаг, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нарийвчлан тусгаж өгөөгүй боловч хоршооллыг олон янз хэлбэрээр хөгжүүлэх арга хэмжээнүүд тусгагдсан байна. Тодруулбал “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг эрчимжүүлэх, “Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодыг чадавхжуулах”, “хоршоодын бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог кластерын системээр хөгжүүлнэ” гэх зэрэг ерөнхий байдлаар арга хэмжээ тусгагдсан байна.

1.1.1.7. Жижиг, дунд үйлдвэрлэл болон ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагт хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээгээр өрх, хэрэглэгч болон бэлтгэн нийлүүлэгч нар хамтарсан, хоршоолсон хуулийн этгээдүүдийг бий болгож, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгайлан тодорхойлоогүй байна.

1.1.1.8. Гэсэн хэдий ч “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд 2021–2024 онд Сүхбаатар аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Нэг суурин – нэг бүтээгдэхүүн” аяныг зохион байгуулах, хоршсон хөрөнгө оруулалтын ач холбогдлын талаарх ойлголт, мэдлэгийг үйлдвэр эрхлэгчдэд нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагааг тусгасан байна.

1.1.1.9. Эдгээр арга хэмжээ нь ЖДҮ-ийн өсөлт, хамтын оролцоонд суурилсан бизнесийн хэлбэрийг хөгжүүлэхэд үр нөлөө үзүүлэх боловч орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хамтын эдийн засгийг дэмжих талаар тодорхой байдлаар төлөвлөж, үр дүнгийн үзүүлэлтийг тогтмол хэмжих механизмыг бүрдүүлэх шаардлага оршин байна.

1.1.1.10. Цаашид хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд өрх, хэрэглэгч олноороо (хэдэн зуу, мянгаар) нэгдэн хамтрах, хорших хөдөлгөөний ач холбогдол, бодит өгөөжийг олон нийтэд системтэй таниулах чиглэлийн арга хэмжээг тусгай бүлэг/зорилт болгон тусгаснаар бизнесийн загвар төлөвшиж, ЖДҮ-гийн санхүүжилт, кластер, бүтээмжийн өсөлт бодитоор хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

1.1.2. Олон зуун, хэдэн мянган гишүүнтэй хоршоолсон хуулийн этгээдийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгах шаардлагатай байна.

1.1.2.1. Сүхбаатар аймаг 2024 оны байдлаар 19,706 өрхтэй, үүнээс малчин өрх 45.5 хувь буюу 8,966, суурин хүн ам 66,155, үүнээс малчин өрхийн ам бүл 48.9 хувь буюу 32,401 байна. Харин малтай өрх 11,245 байна. Нэг өрхийн сарын дундаж орлого 2024 оны байдлаар 2,423.3 мянган төгрөг /улсын дундаж/ байх бөгөөд Сүхбаатар аймгийн нийт өрхийн жилийн орлого 2024 онд 573.0 тэрбум төгрөг орчим байна. Үүнээс малчин өрхөд ногдох орлого 260.7 тэрбум төгрөг, татварын байгууллагад тайлагнасан нийт ажил олгогчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого 199.6 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр 82.1 тэрбум төгрөг, халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж 16.5 тэрбум төгрөг, үлдсэн 14.1 тэрбум орчим төгрөгийн орлого нь албан бус хөдөлмөр эрхлэлтийн орлого байхаар байна. Бүртгэлтэй ажилгүй иргэд 2024 оны эцэст 234 байсан бол 2025 оны 06 сарын байдлаар 434 болж нэмэгдсэн бөгөөд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 29,221 байна.

1.1.2.2. Аймгийн хэмжээд 2024 онд нийт 329.4 тэрбум төгрөгийн зээл олгосон, 252.1 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн байна. Аймгийн нийт зээлийн 40.1 хувь нь хэрэглээний зориулалтаар, 21.2 хувь нь хөдөө аж ахуйн зориулалтаар, 13.9 хувь нь орон байр худалдан авах, засварлах зориулалтаар, 17.9 хувь нь бизнесийн зориулалтаар, 6.9 хувь нь төслийн зориулалтаар тус тус олгосон байна. Эндээс үзэхэд 132.1 тэрбум төгрөгийн зээлийг хэрэглээний зориулалтаар, 45.8 тэрбум төгрөгийн зээлийг орон байр худалдан авах, засварлах зориулалтаар буюу хэрэглээ болон орон байрны зориулалттай зээл 177.9 тэрбум төгрөг байна. Энэ нь аймгийн нийт өрхийн 573.0 тэрбум төгрөг орлоготой харьцуулахад 31.0 хувьтай тэнцэж байна.

1.1.2.3. Сүхбаатар аймаг дахь банкны нэгжүүдээс иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2024 оны эцэст 307.9 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдлийн 57.0 хувь нь Баруун-Урт суманд, 43.0 хувь нь бусад сумдад хамаарч байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл 1.5 тэрбум төгрөг, энэ нь нийт зээлийн үлдэгдлийн 0.5 хувийг эзэлж байгаа нь улсын хэмжээнд хамгийн бага үзүүлэлт болсон байна. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн харилцах дансны үлдэгдэл 65.3 тэрбум төгрөг, харин хадгаламжийн хувьд 2024 оны эцэст хадгаламжийн үлдэгдэл 175.5 тэрбум, үүнээс иргэдийн хадгаламж 144.2 тэрбум төгрөг байна.

1.1.2.4. Арилжааны даатгалд 2024 онд 1,456.3 сая төгрөгийг төвлөрүүлж, нөхөн төлбөрт 824.0 сая төгрөгийг буцаан авсан байна. Өөрөөр хэлбэл 632.3 сая төгрөгийн даатгалын төлбөр нь даатгалын компаниудад ашиг болон үлдсэн байна. Хоршоолсон банк, хоршоолсон даатгалын компаниуд өндөр хөгжилтэй олон улс, орны банк, санхүүгийн салбарын тэргүүлэгч хуулийн этгээдүүд болсон байна. Дээр дурдсан банк, даатгалын мэдээллүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд орон нутгийн иргэд, үйлчлүүлэгч нар нь хувь эзэмшдэг, 1 гишүүн 1 саналын эрхтэй хоршоолсон банк, даатгалын компаниуд Сүхбаатар аймагт бий болох боломжтой байна.

1.1.2.5. Тухайлбал арилжааны банкны хадгаламжийн үлдэгдэл 175.5 тэрбум төгрөг байгаа нь арилжааны банк байгуулах өөрийн хөрөнгийн доод хэмжээ болох 100 тэрбум төгрөгийн шаардлагыг хангахаар байна. Мөн даатгалын компани байгуулах дүрмийн сангийн доод хэмжээ нь даатгалын хугацаа төрлөөс хамааран 5-6 тэрбум төгрөг, давхар даатгал бол 15 тэрбум төгрөг байна. Иймд орон нутагт иргэд, үйлчлүүлэгч нь хувь эзэмшдэг хоршоолсон банк, даатгалын компани байгуулагдах боломжтой байна.

1.1.2.6. Сүхбаатар аймагт 2025 оны 10-р сарын байдлаар улсын бүртгэлд нөхөрлөл 56, хоршоо 454, ХХК 1,013, нийт 1,523 хуулийн этгээд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн байна. Нөхөрлөл 56 байгаагаас 1-5 гишүүнтэй 43, 5-10 гишүүнтэй 11, 10-20 гишүүнтэй 2 байна. Хоршооны хувьд 9-10 гишүүнтэй 369, 10-20 гишүүнтэй 65, 20-50 гишүүнтэй 12, 50-аас дээш гишүүнтэй 8, нийт 454 хоршоо байна. Түвшинширээ, Баяндэлгэр сумдад 81-98 гишүүнтэй, түүхий эдийн худалдаа, мал аж ахуйн үйлдвэрлэл чиглэлээр 3 хоршоо 2014 онд байгуулагдсан нь аймгийн хамгийн их гишүүнтэй хоршоонууд байна. Өөрөөр хэлбэл хамтын эдийн засаг бодит байдал дээр бий болоогүй, эхлэлийн шатанд байна. Хамтрах, хоршихын бодит үр нөлөө нь олон зуу, хэдэн мянгаар хорших үед бий болдог байна.

1.1.2.7. Сүхбаатар аймагт 2024 оны байдлаар татварын байгууллагын мэдээллээс авч үзэхэд бичил ангилалд 1116 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 56.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, дунд ангилалд 6 аж ахуйн нэгж 68.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, жижиг ангилалд 314 аж ахуйн нэгж 194.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого тус тус тайлагнасан байна. ААНБ-уудын багагүй хувь нь Х тайлан гаргаж илгээдэг байна. Тодруулбал 1116 бичил ААНБ-аас 839 нь Х тайлан илгээсэн, 314 жижиг ААНБ-аас 2 нь Х тайлан илгээсэн байна.

1.1.2.8. Аймгийн 2024 оны дотоодын нийт бүтээгдэхүүний мэдээлэл улсын хэмжээнд шинэчлэгдэж гараагүй байх тул 2020-2023 оны ДНБ-ий мэдээллийг дараах хүснэгтээр харуулав. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг бүтцээр нь ангилж үзэхэд хөдөө аж ахуй 40.4 хувь, үйлдвэрлэл 34.7 хувь, 24.9 хувийг үйлчилгээ тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 2. Сүхбаатар аймгийн ДНБ

(сая төгрөг)

Салбар	2020	2021	2022	2023
ДНБ, зах зээлийн үнээр	471,130.14	590,072.32	770,709.01	711,957.98
Хөдөө аж ахуй	203,755.25	278,639.41	343,970.49	287,565.31
Газар тариалан	3,933.24	7,173.61	7,799.69	17,372.12
Мал аж ахуй	199,748.11	268,619.33	330,924.03	269,978.75
ХАА-н бусад	73.91	2,846.47	5,246.77	214.43
Үйлдвэрлэл	162,071.59	196,547.52	280,165.51	246,938.66
Уул уурхай, олборлох	101,169.16	132,780.35	203,926.44	159,334.51
Боловсруулах	51,910.69	53,932.35	65,535.56	77,628.47
Цахилгаан, хий, уур хангамж; усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа	6,602.46	7,413.23	7,806.69	5,520.40
Барилга	2,389.28	2,421.59	2,896.83	4,455.29
Үйлчилгээ	105,303.30	114,885.39	146,573.01	177,454.01
Худалдаа, зочид буудал, зоогийн газар	15,727.01	16,914.99	32,085.17	29,849.56
Тээвэр, мэдээлэл, холбоо	2,432.22	2,506.30	5,318.22	5,929.99
Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	27,966.03	32,739.75	32,387.18	42,329.69
Бусад үйлчилгээ	59,178.04	62,724.36	76,782.44	99,344.77

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.1.2.9. Дээрх дурдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт болох ДНБ, хүн ам, өрхийн тоо, газар нутгийн байршил, төсвийн орлого, зарлага, ААНБ-ийн тоо, тээврийн хэрэгслийн тоо (бүртгэлтэй 21,975, оношилгоонд орсон 12,054), өрхийн сарын дундаж зарлага, зарлагын бүтэц зэрэг мэдээлэлд үндэслэн аймгийн гаднаас худалдан авч буй бараа, бүтээгдэхүүний хэмжээ, эзлэх хувийг дараах байдлаар тооцоолсон. Үүнд: нийт худалдан авалтыг 530 орчим тэрбум төгрөг; хүнс, ундаа 23 хувь 121.9 тэрбум төгрөг; шатах тослох материал 17 хувь 90.1 тэрбум төгрөг; барилгын материал 15 хувь 79.5 тэрбум төгрөг; машин техник сэлбэг 21 хувь 111.3 тэрбум төгрөг; эм, эмнэлгийн хэрэгсэл 5 хувь 26.5 тэрбум төгрөг; өргөн хэрэглээний бараа (хувцас, электроник, гэр ахуй) 19 хувь 100.7 тэрбум төгрөг гэсэн бүтэцтэй байна.

1.1.2.10. Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийн зарим нэр төрлийн /төмс⁴, хүнсний ногоо, сүү, өндөг, сурагчийн дүрэмт хувцас гэх мэт/ бүтээгдэхүүний тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд дараах хувь хэмжээгээр дотоодын хэрэгцээгээ хангаж байна. Үүнд: Төмсний хэрэгцээний 22 орчим хувь, хүнсний ногооны хэрэгцээний 11 орчим хувь, сүүний 58 орчим хувь, өндөгний 13 орчим хувийг тус тус дотоодоосоо хангаж, сурагчийн дүрэмт хувцсыг огт үйлдвэрлэдэггүй байна.

1.1.2.11. Сүхбаатар аймагт хүнс, барилгын материал, өргөн хэрэглээний бараа, машин техникийн худалдан авалтын дийлэнхийг аймгийн гаднаас худалдан авалт хийж байгаа, дотоодын үйлдвэрлэлийн хангалт 10–60%-ийн түвшинд сул, хоршооллын тогтолцоо жижиг бүлгийн түвшнээс хэтрээгүй, аймгийн эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгох боломжийг бүрэн ашиглагдахгүй байгааг харуулж байна. Иймд орон нутагт хүнс, барилгын материал, машин механизмын засвар үйлчилгээ, сүүний үйлдвэрлэл, ногоо тариалалт, оёмол бүтээгдэхүүн, нийлүүлэлтийн кластер зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр дотоодын зах зээлийг орлох бодит боломж өндөр байна.

1.1.2.12. Тухайлбал Сүхбаатар аймгийн 2024 онд шинээр худалдан авсан тээврийн хэрэгслийн мэдээллээс⁵ үзэхэд 835 суудлын автомашинд 25.1 орчим тэрбум төгрөг, 215 ачааны автомашинд 8.6 орчим тэрбум төгрөг, зүтгүүр (172) болон чиргүүл (243)-д 21.1 орчим тэрбум төгрөг, бусад тээврийн хэрэгсэл, механизмыг худалдан авахад 8.5 орчим тэрбум төгрөг, нийт 63.3 орчим тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Энэхүү дүнд 2024 онд импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийг хамруулсан бөгөөд харин 2024 оноос өмнө импортлогдсон боловч 2024 онд нийслэл болон бусад аймгаас Сүхбаатар аймаг руу нийлүүлэгдсэн тээврийн хэрэгслийн тоон мэдээлэл, худалдан авалтын дүн хамрагдаагүй болно.

1.1.2.13. Иймд орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд орон нутагт үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүний дотоодоос хангаж буй хувь болон 100-аас дээш гишүүнчлэлтэй хоршоолсон хуулийн этгээдийн тоо, тэдгээрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эдийн засагт эзлэх хувь хэмжээг шалгуур үзүүлэлтээр тусгаж, холбогдох арга хэмжээний суурь ба хүрэх түвшнийг тодорхойлж, төлөвлөх шаардлагатай байна.

⁴ Төмс, хүнсний ногоо, сүү, өндөгний хэрэгцээ, хангалтын хувийг ХХААГ-ын мэдээлэлд үндэслэсэн.

⁵ Сүхбаатар аймгийн автотээврийн төвийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэсэн.

1.1.2.14. Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкнууд, уул уурхайн компаниуд, шатахуун борлуулалтын компаниуд, даатгалын компаниудын ААНОАТ-аа орон нутагт тайлагнадаггүй байна. Эдгээр хуулийн этгээдийн орон нутгаас олсон ашгийн татварын 40 хувь аймгийн төсөвт төвлөрөх боломжтой бөгөөд төвлөрсөн хөрөнгийг сумдын хоршоо хөгжүүлэх санд “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.1.1 /Улсын болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө/ дэх заалтын дагуу хуваарилж, ЖДҮ, үйлчилгээг хөгжүүлэх боломжтой байна.

1.1.2.15. Иймд орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийн ААНОАТ-ыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэлтийн хувь гэсэн шалгуур үзүүлэлтийг тусгаж, холбогдох арга хэмжээний суурь ба хүрэх түвшнийг тодорхойлж, төлөвлөх шаардлагатай байна.

1.2. ЖДҮ, үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд төсвийн нөөц боломжийг бүрэн дайчлаагүй байна.

1.2.1. Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны батлагдсан төсөв 7.1 хувийн зарцуулалттай буюу 2 тэрбум төгрөг ашиглалтгүй байна.

1.2.1.1. Сумдын 2024 оны төсөвт нийт 2,165.0 сая төгрөгийг Хоршоо хөгжүүлэх санд хуваарилан баталсан хэдий ч гүйцэтгэлээр зөвхөн 155.0 сая төгрөгийг (7.1%) нийт 4 хоршоодод хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгосон нь сангийн зорилт болох хоршоодоор дамжуулан ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг өсгөх, амьжиргааг дэмжих болон орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах чиглэлд бодит үр дүн гаргахад хангалтгүй байна.

1.2.1.2. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн олголт бага хувьтай байгаа нь хоршоод нь тавигдах шаардлага, шалгуурыг хангаж чадахгүй байгаатай холбоотой, мөн “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлсэн нь тодорхой хэмжээнд нөлөөлсөн байна.

1.2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хүнс, барааны зах барих, мөн өрхийн бичил үйлдвэрлэл эрхлэгч нарт зориулсан хямд түрээстэй ажлын байр барих боломжтой байна.

1.2.2.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр ажлын байр бий болгоход чиглэсэн төсөл, арга хэмжээг харьцангуй бага төлөвлөж хэрэгжүүлж байна. Тухайлбал Асгат сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 2024 онд “Ахуй үйлчилгээний төв шинээр барих” төсөл, арга хэмжээг 575.0 сая төгрөгөөр төлөвлөн, хэрэгжүүлж, 2025 онд ашиглалтад орж халуун усны газар ажиллаж байна, бусад өрөөнүүд халаалтад холбогдоогүй учир ашиглаж эхлээгүй байна. Харин аймгийн ОНХС болон бусад сумдын хувьд 2024 онд ажлын байр бий болоход чиглэсэн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна.

1.2.2.2. Сүхбаатар аймгийн өрх, иргэд олноороо (хэдэн зуу, мянгаар) хамтарч, хоршиж хэрэглэгч ба эзэн, нийлүүлэгч ба эзний зарчмаар ажиллах хоршоолсон хуулийн этгээдүүд байгуулахыг дэмжих, ач холбогдлыг таниулах зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтын төсөл арга хэмжээнүүдийг аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад баталж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь ОНХС-ийн үйл ажиллагааны 4.2.7, 4.4.7 дахь заалт

“Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт”-тай нийцэхээр байна.

1.2.2.3. Харин аймгийн өрх, иргэд иргэд олноороо (хэдэн зуу, мянгаар) хамтарч, хоршиж хэрэглэгч ба эзэн, нийлүүлэгч ба эзний зарчмаар ажиллах хоршоолсон хуулийн этгээдүүдийг дэмжихийн тулд тэдгээрийн байгуулсан үйлдвэрийн газар, байршилд шаардлагатай эрчим хүчний болон бусад дэд бүтцийг холбогдох хуульд заасны дагуу үндсэн шугам сүлжээний ажлыг хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Жишээлбэл өндөгний аж ахуй, сурагчийн дүрэмт хувцасны оёдлын үйлдвэр, төмс, хүнсний ногооны тариалалтын талбай, сүүний төрөлжсөн фермерүүд гэх мэт хоршоолсон үйлдвэрлэлийг дэмжихэд шаардлагатай цэвэр ус хангамж, дулааны болон цахилгаан эрчим хүчний үндсэн шугам, сүлжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой байна. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан өргөн хэрэглээний хүнс, бараа худалдаалдаг зах байгуулах боломжтой байна.

1.2.2.4. Орон нутагт үйлдвэр эрхлэгчдийг хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтын хүрээнд “Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-ын барилга, байгууламжид одоогийн байдлаар 7 иргэн, аж ахуй нэгж хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээс төлж, үйл ажиллагаагаа явуулж байна. Бизнес эрхлэгчид өргөжиж чадахгүй байгаа нэг шалтгаан нөхцөл нь аж ахуй нэгжийн төлөх дулааны эрчим хүчний төлбөр өрхийн хэрэглэгчдээс 5-6 дахин их байгаа нь хүндрэл үүсгэж байгаа учир хямд зардлаар, эдийн засгийн үр өгөөж өндөр, нарны эрчим хүчээр дулаан, цахилгааны асуудлыг шийдвэрлэсэн бизнес инкубатор төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд АЗДТГ-аас худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран зураг, төсвийг боловсруулж батлуулсан байна.

1.2.3. Гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулах шаардлагатай байна.

1.2.3.1. Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т “Энэ хуулийн 43.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, соёл, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаарх журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.” гэж заасан.

1.2.3.2. Энэхүү заалтын хүрээнд Сүхбаатар сум “Боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-г байгуулж, уул уурхайн компанийн илүү ажлын байрны төлбөрийг тус санд төвлөрүүлэн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, арга хэмжээнд зарцуулж ирсэн. Тус сангийн зарцуулалтаас үзэхэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, арга хэмжээ нь малжуулах төсөл, арга хэмжээнүүд байна.

1.2.3.3. Харин тус суманд үйл ажиллагаа явуулж буй “Тэнүүн Дархан хаан хоршоо” нь сумын нийт малчдын 80 хувийг хамруулах зорилттой ажиллаж байна. Сум, орон нутагт ажлын байр, үйлдвэрлэл, хоршоог нэмэгдүүлэхийн тулд дээрх хоршоо болон үүнтэй адил зорилт бүхий олон малчид, нийлүүлэгчдийг хамруулсан хоршоололд шаардлагатай дэд бүтцийн шугам сүлжээг сумын БЭМХЭДС-аас шийдвэрлэж өгөх нь үр нөлөөлөл ихтэй, ач холбогдолтой, шууд үр дүн үзүүлэхээр байна.

1.2.3.4. Бусад уул уурхайтай Түмэнцогт, Асгат, Мөнххаан, Эрдэнэцагаан зэрэг сумдын хувьд одоогоор Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан төлбөрийг тус хуульд заасны дагуу тусгай сан байгуулж, төвлөрүүлж, хөдөлмөр эрхлэлт, хоршоолсон ЖДҮ, үйлчилгээнд шаардлагатай дэд бүтцийг бий болгох, дэмжих төсөл арга хэмжээнд зарцуулах нь оновчтой байна.

1.2.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд орон нутгийн төсвөөс 2024, 2025 онд 82.7-86.7 сая төгрөгийг хуваарилаагүй нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2.4.1. Орон нутгийн 2024, 2025 оны төсөвт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөрөнгө хуваарилж, батлаагүй байна. Тодруулбал “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д аймгийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн орон нутгийн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байх заалтыг хэрэгжүүлээгүй байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлого 28,915.5 сая төгрөг, 2025 онд 27,569.8 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд 0.3-иар тооцоход багадаа 82.7-86.7 сая төгрөгийг ХЭДС-д хуваарилахаар байжээ.

1.2.4.2. Дээрх заалтын хүрээнд ХХҮГ-аас орон нутгийн төсөвт хөрөнгө тусгуулах талаар санал боловсруулж хүргүүлж байсан, мөн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитын тайланд тус асуудлын талаар тайлагнаж, санал, зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжээгүй.

1.2.4.3. Сүхбаатар аймгийн ХХҮГ-ын ХЭДС-ийн хэрэгжүүлж буй дараах хөтөлбөр, төслүүд эрэлт хэрэгцээ ихтэй байна. Тухайлбал “Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Шилдэг Старт-Ап залуу, залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох” хөтөлбөр, төслүүд эрэлттэй байдаг байна. Иймд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасны дагуу орон нутгийн төсвөөс аймгийн ХЭДС-д төсөв батлах шаардлагатай байна.

1.2.4.4. Орон нутгийн төсвөөс ХЭДС-д хөрөнгө батлах нь хөдөлмөрийн зах зээлд оролцоог нэмэгдүүлэх, зорилтот бүлгийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх, бичил бизнес, старт-ап-ийг хөгжүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, улмаар орон нутгийн эдийн засгийн идэвхжил болон тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг сайжруулах бодит үр дүн гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.

**БҮЛЭГ Б. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ
ЗЭЭЛД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД ШИНЭЭР
АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА АСУУДЛЫГ
ХАМТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРЧМААР ШИЙДВЭРЛЭХ
БОЛОМЖТОЙ БАЙНА.**

2.1. Сүхбаатар аймгийн 40 аж ахуйн нэгж татварын хөнгөлөлтөд хамрагдаж, 115.9 сая төгрөгийн татварын буцаан олголт авсан бөгөөд аймгийн татвартай харьцдаг 404 аж ахуйн нэгж 2024 онд төрийн худалдан авалтын 25.8 хувийг ханган нийлүүлсэн байна.

2.1.1. Орон нутгийн төсвийн зарлага, төрийн худалдан авалтын 25.8 хувийг аймгийн татвартай харьцдаг ААНБ-ууд, 74.2 хувийг бусад аймаг болон нийслэлд бүртгэлтэй ААНБ-ууд ханган нийлүүлж байна.

2.1.1.1. Төрийн худалдан авалтаар орон нутгийн иргэд болон ажиллагсад нь хувь эзэмшдэг хоршоолсон хуулийн этгээдүүдээр төрөөс зарласан тендерийн ажлыг хийж гүйцэтгүүлж, орон нутгийн хоршоолсон хуулийн этгээдүүдийг төрөөс дэмждэг олон улсын сайн жишээнүүд байна. Тухайлбал:

- Итали улсын Карпи хотын С.М.В хоршоолсон хуулийн этгээдийг иргэд болон ажиллагсад нь хувь эзэмшдэг бөгөөд 2022 онд “шинэ Gaslini” эмнэлгийн 164.4 сая еврогийн барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.
- Францын SCOP хоршоолсон хуулийн этгээд (модон хийц/карказ, модон шал гэх мэт барилгын ажил) 72.6 сая долларын тендерт шалгарч, гүйцэтгэсэн байна.
- Испанид “Construcciones Balazote, Sociedad Cooperativa Limitada” хоршоолсон хуулийн этгээд Төрийн өмчит компанийн зарласан 75 айлын орон сууцны 10.5 сая долларын төсөвт өртөгтэй тендерт хамтран гүйцэтгэгчээр шалгарч, гүйцэтгэсэн байна.

2.1.1.2. Сүхбаатар аймгийн төрийн байгууллагуудын төсвийн зарлагын мэдээллээс хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага руу шилжүүлсэн гүйлгээ буюу төрийн худалдан авалтын мөнгөн дүнг тооцоолж үзэхэд 79.5 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Үүнээс Сүхбаатар аймгийн татварын байгууллагатай харьцдаг ААНБ-аас худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний үнийн дүн 20.5 тэрбум төгрөг байна. Дээрх 79.5 тэрбум төгрөгийн худалдан авалтын 49.8 хувь буюу 39.6 тэрбум төгрөгийн худалдан авалт нь зам, барилгын ажил, их засвар, тоног төхөөрөмжийн худалдан авалт эзэлж байна.

2.1.1.3. Мөн бараа үйлчилгээний бусад зардал 11.5 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 4.5 тэрбум төгрөг, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 4.3 тэрбум төгрөг, тээвэр шатахуун 3.8 тэрбум төгрөг, хоол, хүнс 3.2 тэрбум төгрөг, урсгал засвар 3.1 тэрбум төгрөг, багаж, техник, хэрэгсэл 1.7 тэрбум төгрөг байна.

2.1.1.4. Орон нутаг дахь төсвийн байгууллагуудад бараа, ажил, үйлчилгээг тендер шалгаруулалтаар болон шууд худалдан авалтаар нийлүүлсэн ААНБ-уудын нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт мөнгөн дүнгээр эрэмбэлж үзэхэд дараах ААНБ-ууд хамгийн их дүнтэй бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн байна.

**Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж
буй бодлогын хэрэгжилт, үр дүн**

Хүснэгт 3. Их дүнтэй бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн ААНБ-ууд (сая төгрөг)

№	Компанийн нэр	Мөнгөн дүн	№	Компанийн нэр	Мөнгөн дүн
1	МОНГОЛ ЗАМ ГРУПП ХХК	8,306.8	29	МОБИНЕТ ХХК	423.7
2	ИХМОДУН ХХК	5,191.4	30	БАРУУН-УРТ ЭМ ХАНГАМЖ ХХК	407.7
3	АЛСЫН ШАР ЗАМ ХХК	2,348.8	31	ОЙЖУУЛАЛТ ХАЙЛААСТ ХХК	399.6
4	НИК ХХК	2,277.5	32	ЖАВХЛАНТСҮХ БААТАР ХХК	388.0
5	ӨСӨХДЭЛГЭР УНДРАХ ХХК	1,905.8	33	МӨНХ САЙН ҮҮД ХХК	373.3
6	МОНМАРС ХОЛДИНГ ХХК	1,899.5	34	СҮХБААТАРЫН ЖИНЧИН ХХК	366.3
7	ПРОФЭЙШНЛ КОНСТРАКШН СЕРВИС ХХК	1,733.4	35	МОНОС СҮХБААТАР ХХК	358.4
8	ЁСТБЭЙС СЕРВИС ХХК	1,647.6	36	МГ ХАН-УУЛ ХХК	357.2
9	ЖАВХЛАНХҮСЛЭН ХХК	1,616.5	37	ЭФ АЙ ЭФ ӨҮ ХХК	357.1
10	БУЯНТ-АС ХХК	1,574.3	38	ХАВИРГЫН УНДАРГА ХХК	343.8
11	МЭЗ ХХК	1,569.8	39	ЭНТО ХХК	343.6
12	ДБЭХС ТӨХК	1,533.9	40	ЦАСТ ХАН ХӨХИЙ ХХК	319.6
13	НАНО-ЭКОЛОГИ ХХК	1,458.5	41	ЭС ЖИ СИ ХХК	318.3
14	ТОГООН ТӨМӨР КОНСТРАКШН ХХК	1,150.3	42	ГРАНДФОРЕСТ ХХК	308.6
15	ХӨХХАЙРХАН ТРЕЙД ХХК	1,069.9	43	СОД ЭРДЭНЭ АЛТАЙ ХХК	300.0
16	МӨНХ ТАЙЖ АЛТАЙ ХХК	986.9	44	ТАЛЫН ГАЛ ХК	280.0
17	ЭМ БИ БИ СИ ХХК	803.2	45	АЛТАЙН ҮНДЭС КОНСТРАКШН ХХК	276.6
18	ХАЙЛААСТ ГАРАМ ХХК	760.0	46	КЛАССИКРОУД ХХК	271.0
19	ЭКСИМ МИНЕРАЛ РЕСУРС ХХК	714.0	47	ТАЛЫН БАЯН ЭРХЭТ ХХК	264.4
20	ДУЛААН СУВАГ ХХК	652.8	48	ЭНХИЙН ШҮҮДЭР ХХК	245.1
21	ТАВАНБОГД ХХК	632.5	49	АЗИЯКОМПЛЕКТ МОНТАЖ ХХК	242.3
22	ШИРЭЭТЦАГААН УС ХХК	616.9	50	БАЯН МӨНХ ХУНДАР ХХК	237.8
23	ТЭМҮҮЛЭЛ ӨРГӨӨ ХХК	554.3	51	ТЕХНИКИЙН ЦОГЦ ШИЙДЭЛ ХХК	232.2
24	ТҮВШИНМӨНХ ХХК	539.1	52	ОТГОНТӨГӨЛ ХХК	231.0
25	ГОМ-ИЛЧ ХХК	527.5	53	АТАР-ИРЭЭДҮЙ ХХК	226.1
26	ДАШВААНЖИЛ ХХК	471.1	54	ИНТЕРВОРЛД ХХК	206.7
27	СЕТУНАРИ ХХК	466.7	55	БАЯЛАГ ГОВЬ ХХК	204.0
28	ЕДИЛЖАЙБХ ХХК	423.7			

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс

2.1.1.5. Эндээс дүгнэхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа тендерт орон нутгийн иргэдийн гишүүнчлэлтэй хоршоолсон хуулийн этгээдүүд оролцох боломжтой байна. Тухайлбал бүх төрлийн авто машин, тоног төхөөрөмж нийлүүлэх тендер, замын ажил, сургууль, цэцэрлэг гэх мэт бүх төрлийн барилгын ажлын тендер, мөн зураг төслийн үйлчилгээ болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, тодотгох зөвлөх үйлчилгээний тендер зэргийг Сүхбаатар аймгийн нийт өрхийн олонх нь гишүүнчлэлтэй хоршоолсон хуулийн этгээд гүйцэтгэснээр хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэл сайжирч, засварын ажлын зардал багасаж төсвийн зарцуулалтын үр ашиг нэмэгдэж, орон нутагт ажлын байр шинээр бий болох боломжтой байна.

2.1.1.6. Өөрөөр хэлбэл хамтын эдийн засгийн олон улсын бодит жишээ, төрийн худалдан авалтын хэмжээ, хүний нөөцийн боломж зэрэг хүчин зүйлсийг нэгтгэн үзвэл Сүхбаатар аймгийн хүн амын багагүй хувийг гишүүнчлэлдээ багтаасан хоршоолсон хуулийн этгээдүүд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын тендерт оролцож, чанартай гүйцэтгэл үзүүлэх боломж байна.

2.1.1.7. Иймд цаашид төрд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний тендерт орон нутгийн хоршоолсон /хэдэн зуу, мянгаар/ хуулийн этгээд оролцох боломжийг

уриалах, сурталчлах, энэ талын мэдлэг, ойлголтыг олон нийтэд тогтмол мэдээлэх шаардлагатай байна.

2.1.2. Хоршоолсон эдийн засаг буюу хамтын эдийн засаг хөгжсөн улс, орнуудын жишгээр хоршоодод чиглэсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого хэрэгжих боломжтой байна.

2.1.2.1. ААНОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс бага хуулийн этгээдийн ногдуулсан албан татварыг 90 хувийг хөнгөлдөг, мөн хуулийн 22.5.1-д заасны дагуу Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар хөнгөлдөг, түүнчлэн 22.5.15-д заасны дагуу орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар хөнгөлдөг. Сүхбаатар аймагт 2024 онд эдгээр хөнгөлөлтөд 40 аж ахуйн нэгж хамрагдаж, нийт 115.9 сая төгрөгийн татварын буцаан олголт авсан байна.

2.1.2.2. Манай улсын ЖДҮ-ийг дэмжих тухай хуульд татварын бодлогоор дэмжих, мөн холбогдох татварын хууль тогтоомжуудаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарт эдлүүлдэг. Харин хоршоолсон хуулийн этгээдэд чиглэсэн тусгайлсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалт, зохицуулалт байдаггүй байна. Харин олон улсад хоршоолсон хуулийн этгээдийг татварын бодлогоор дэмждэг дараах сайн жишээнүүд байна. Тухайлбал:

- Испани улсад хоршоолсон хуулийн этгээд ашгийн тодорхой хэсгийг Reserve Fund (нөөц сан) руу заавал хуримтлуулах бөгөөд энэ нь татвар ногдох орлогоос хасагдаж, тооцогддог байна.
- АНУ-д хоршоолсон хуулийн этгээдийн гишүүддээ хуваарилсан ашгийг татвар тооцох ашигт оруулдаггүй буюу хасаж тооцдог бөгөөд хоршоолсон хуулийн этгээдийн татварын ачаалал буурдаг байна.
- Итали улсад хоршоолсон хуулийн этгээдийн гишүүдэд хуваарилдаггүй буюу дотоод нөөцдөө шилжүүлсэн ашгийн хэсэгт татварын хөнгөлөлт үйлчилдэг байна.

2.1.2.3. Иймд өндөр хөгжилтэй орнуудын туршлагад тулгуурлан хоршоолсон хуулийн этгээдийг татварын бодлого болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжих боломжтой гэж үзэж байна. Энэ асуудлыг нарийвчлан судалж, шинжилгээ хийсний үндсэн дээр практикт хэрэгжүүлбэл хоршоолсон буюу хамтын эдийн засгийг хөгжүүлэхэд чухал түлхэц болно.

2.1.3. Ажил олоход хүндрэлтэй иргэнд ажил олгосон ААНБ-ууд санхүүгийн дэмжлэгт хамрагдах боломжийг олон нийтэд үр нөлөөтэй сурталчлах, төрийн байгууллагуудын мэдээлэл солилцоог сайжруулах шаардлагатай байна.

2.1.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д "ажил олоход хүндрэлтэй иргэн" гэж хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-д заасан иргэн, хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг хэлнэ гэж заасан.

2.1.3.2. Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно гэж заасан байна.

2.1.3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтын хүрээнд 2024 онд 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан 2 аж ахуй нэгж, хуулийн этгээдэд 14,740.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон бол 2025 оны 11 дүгээр сарын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан 1 аж ахуй нэгж, хуулийн этгээдэд 8,712.0 мянган төгрөгийн урамшуулал олгохоор байна.

2.1.3.4. Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн системийн шинэчлэлт хийгдэж байгаатай холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэл төлөгч иргэдийн дэлгэрэнгүй мэдээлэл шууд гарах боломжгүй байгаа нь ХХҮГ болон бусад төрийн байгууллагууд ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажилд авсан ажил олгогчийн мэдээллийг шүүж харахад хүндрэлтэй байна.

2.1.3.5. Өөрөөр хэлбэл, ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажиллуулсан ажил олгогчийн тоог тодорхойлох болон ажил олгогчид урамшууллын талаар мэдээлэлгүйгээр ийм иргэдийг ажилд авсан эсэхийг үнэлэх боломжгүй байна. Иймд холбогдох байгууллагуудын мэдээлэл солилцооны тогтолцоог сайжруулж, ажил олоход хүндрэлтэй иргэдийн жагсаалтыг регистрийн дугаарт тулгуурлан бүрдүүлэх, түүнчлэн нийгмийн даатгалын байгууллагын шимтгэл төлөлтийн мэдээллийн сангаас холбогдох хайлт, шүүлт хийх боломжийг ханган жил бүр дүн шинжилгээ хийж ажиллах шаардлагатай байна.

2.2. Хамтын эдийн засгийг орон нутагт төлөвшүүлж, дэмжин хөгжүүлснээр үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар олгосон газрын ашиглалт сайжирч, тээвэр-логистикийн өртөг буурч, хэрэглэгч-нийлүүлэгчийн оролцоо эзний зарчмаар бэхжиж, улмаар аймгийн дотоодын хэрэгцээг хангах чадвартай, санхүүгийн тогтвортой үйл ажиллагаа бүхий ААНБ-уудын бүтэц төлөвшин бий болох нөхцөл бүрдэнэ.

2.2.1. Улс, орнуудын туршлагаас үзэхэд орон нутгийн иргэд нь хоршоолсон хуулийн этгээд байгуулах замаар бүх төрлийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний үйл ажиллагааг эрхэлж, ажилтай орлоготой болж, дундаж давхаргыг нэмэгдүүлдэг жишгийг нэвтрүүлэх боломжтой байна.

2.2.1.1. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын 2012 оны “Жижиг үйлдвэрлэгчдийн бизнес загварууд: Хөдөө аж ахуйд суурилсан хөгжлийг дэмжих сайн туршлага ба бодлогын зөвлөмж” тайланд жижиг, дунд бизнесүүд хамтарч, хоршоолсноор бэлтгэн нийлүүлэгч болон худалдан авагч талуудтай ашигтай хэлэлцээр хийх, том зах зээлд нэвтрэх, тээвэр, логистикийн болон бусад зардлаа хэмнэх, мөн зээл, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд давуу тал бий болдог талаар дурджээ.

2.2.1.2. Хамтрахгүй, хоршоолохгүй байх нь бизнесүүд тус тусдаа жижиг үйл ажиллагаа эрхэлж, нэгжийн өртөг (түүхий эд, тээвэр, агуулах, маркетинг) өндөр

хэвээр үлдэж, борлуулалтын эргэлт удаашран мөнгөн урсгал гацсанаар татвар, НДШ-ийн өр-алданги хуримтлагдах эрсдэл нэмэгддэг байна. Үүний улмаас их хэмжээний захиалга авах, чанар-стандартаа сайжруулах, ажилтнуудаа тогтоох, ашигт ажиллагаагаа өсгөх боломжууд алдагдаж, зах зээлийн өрсөлдөх чадвар системтэйгээр сулардаг байна.

2.2.1.3. Сүхбаатар аймгийн эдийн засгийн бүтэц, салбарын мэдээллээс авч үзэхэд дараах төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийг олон улсад хөгжсөн хоршооллын буюу хамтын эдийн засгийн зарчмаар хөгжүүлэх боломжтой байна.

2.2.1.4. Тухайлбал газар тариалан, төмс, хүнсний ногоо, улаан буудай, тэжээлийн ургамлын тариалалт, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тахианы аж ахуй (өндөгний үйлдвэрлэл) малын гаралтай түүхийн эдийг боловсруулах үйлдвэр, хүнс, барааны бөөний болон жижиглэнгийн худалдаа, нийтийн болон амины орон сууцны барилга угсралт, шатах, тослох материалын бөөний болон жижиглэнгийн худалдаа, арилжааны банкны болон даатгалын үйлчилгээ, уул уурхайн үйл ажиллагаа (олборлолт, боловсруулалт, тээвэр, борлуулалт) зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээг иргэд нь хувь эзэмшиж, 1 хүн 1 саналын эрхтэйгээр хамтын шийдвэр гаргадаг бизнесийн загвараар хөгжүүлэх боломжтой байна.

2.2.1.5. Өндөр хөгжилтэй улс, орнуудад иргэд буюу хэрэглэгч нь хувь эзэмшдэг (хэрэглэгч = эзэн), мөн малчид, тариаланч, фермерүүд буюу нийлүүлэгч нар нь хувь эзэмшдэг (нийлүүлэгч = эзэн) зарчмаар ажилладаг хоршоолсон хуулийн этгээдийн бодит жишээнүүдийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 4. Хамтын эдийн засаг хөгжсөн улс, орнуудын сайн туршлагууд

№	Зах зээлийн эрэлт хэрэгцээ	Хоршоолсон хэлбэрээр иргэд нийтлэг хэрэгцээгээ хангаж буй олон улсын бодит жишээнүүд
1	Газар тариалан (төмс, хүнсний ногоо)	Швейцар улсын Les Jardins de Cocagne хоршоо (органик ногооны үйлдвэрлэгч-хэрэглэгч хоршоо) Женевад байрлах био хүнсний ногооны үйлдвэрлэгч ба хэрэглэгчийн хамтын хоршоо. 20 жилийн өмнө байгуулагдаж, одоо ойролцоогоор 400 гэр бүл гишүүнтэй, бүх ургац нь зөвхөн хоршооны гишүүдэд очдог.
2	Сүүний фермер (сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл), Тахианы аж ахуй (өндөгний үйлдвэрлэл)	АНУ-ын Fifth Season Cooperative хоршоо (Сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, ногоо, жимс гээд 140 гаруй бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлдэг) нь Висконсин мужийн Viroqua хотод байрлах олон талын гишүүнчлэлтэй хоршоо. Гишүүнчлэлд боловсруулах үйлдвэрүүд, борлуулалт, тээврийн компаниуд, худалдан авагч байгууллагууд, ажилтнууд, хэрэглэгч нар багтдаг.
3	Газар тариалан (улаан буудай, тэжээлийн ургамлын тариалалт)	Австрали улсын CBH Group хоршоо нь 4,000 гаруй гишүүнтэй бөгөөд үр тариа, улаан буудай, арвай, рапс зэргийг тариалдаг, өөрийн агуулах, тээвэр, логистикийн байгууламжтай. Мөн бордоо, тэжээлийн борлуулалт, боловсруулалт (жишээ нь овъёос боловсруулах) зэрэг нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл явуулдаг. Хоршооны бүтцээ хувийн компанид шилжүүлэх саналыг гишүүд олон удаа санал хураалтаар буцааж, фермер-эзэмшлийн загварыг хадгалж ирсэн нь засаглалын сайн туршлага.
4	Малын гаралтай түүхийн эдийг	Бразил улсын Aurora Coop хоршоо нь гахай, шувуу, үхрийн мах, сүүн бүтээгдэхүүн, тэжээл зэрэг малын гаралтай олон

	боловсруулах үйлдвэр	төрлийн бүтээгдэхүүнийг аж үйлдвэрийн хэмжээнд үйлдвэрлэдэг. 11 түнш хоршоо, 100,000 орчим гишүүн фермертэй, Бразилын хамгийн том хүнсний хамтын хоршоонуудын нэг.
5	Хүнс, барааны бөөний болон жижиглэнгийн худалдаа	Япон улсын Кобэ хотын Со-ор Kobe хоршоо нь 1921 онд байгуулагдсан, одоо 1.2 сая гаруй гишүүнтэй – дэлхийн хамгийн том хэрэглэгчийн хоршоо гэж тооцогддог. Хүнс, өдөр тутмын барааны олон салбар дэлгүүр, хүргэлт, гишүүн төвтэй засаглалтай. Хэрэглэгч бүр гишүүнд ногдох ашгийн хувь авдаг, 1 хүн, 1 саналын эрхтэй. Ажилчид бас гишүүн болж, удирдлага, үнэ, үйлчилгээний бодлогод нөлөөлдөг. Бөөний худалдан авалтыг хамтарч хийдэг тул нийлүүлэгчидтэй урт хугацааны, тогтвортой гэрээ байгуулж, бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгаж чаддаг байна.
6	Нийтийн болон амины орон сууцны барилга угсралт	Уругвай улсын – FUCVAM-ийн харилцан туслалцах орон сууцны хоршоод 1960-аад оноос хойш бага орлоготой иргэд нийлж орон сууцны хоршоод байгуулж, FUCVAM гэдэг холбоонд нэгдсэн. Өнөөдөр 22,000 гаруй өрх орон сууцтай болсон, бас 60 орчим төсөл баригдаж байна. Үнэ, чанар: – газар, ашиг, зуучлагчийн зардлыг арилгаснаар зах зээлийн үнээс доогуур; чанарыг хоршооны ерөнхий чуулган, техникийн баг, FUCVAM стандартуудаар хянадаг.
7	Шатах, тослох материалын бөөний болон жижиглэнгийн худалдаа	Канад улсын Federated Co-operatives Limited (FCL) хоршоо нь шатахуун, тос тосолгоо зэрэг бүтээгдэхүүнийг бөөний түвшинд хангадаг. Энэхүү хоршоог орон нутгийн иргэд, фермерүүд гишүүнтэй, мянга мянган хувь хүн, өрх айл эзэмшдэг. Швейцар улсын – Migros хоршоо ба Migrol шатахуун: Migros нь Швейцарын хамгийн том жижиглэнгийн сүлжээ, бүсийн хэрэглэгчдийн хоршоодоос бүрдсэн, хэдэн сая гишүүнтэй хэрэглэгчийн хоршоолсон хуулийн этгээд. Швейцарын хэмжээнд ойролцоогоор 310 шатахуун түгээх станц, хурдан цэнэглэх цэг, автомашин угаалга зэрэг “mobility” сегменттэй.
8	Арилжааны банкны болон даатгалын үйлчилгээ	Франц улсын Credit Agricole хоршоолсон банк нь дэлхийн хамгийн том кооператив санхүүгийн байгууллага, 11 сая орчим “mutual shareholders” буюу гишүүн-эзэмшигчидтэй, зөвлөл, удирдах байгууллагаа сонгож, нэг гишүүн, нэг саналын зарчмаар удирддаг. Нидерланд улсын Achmea хоршоолсон даатгалын байгууллага нь Нидерландын хамгийн том, Европын 3 дахь том кооператив / mutual даатгагч. Achmea-гийн гол эзэмшигч нь Vereniging Achmea нэртэй “харилцагчдын нийгэмлэг” – бүх харилцагч автоматаар уг нийгэмлэгийн гишүүн болдог. Энэ нийгэмлэг Achmea-гийн хувьцааны дийлэнхийг эзэмшиж, компанийн бодлого, стратегийг хянадаг.
9	Уул уурхайн үйл ажиллагаа (олборлолт, боловсруулалт, тээвэр, борлуулалт)	Перу улсын SOTRAMI – 900 уурхайчны хоршоо нь Перугийн өмнөд нутгийн Santa Filomena тосгонд байрлах жижиг уурхай бөгөөд анх 1980-аад оны хямралын үед уурхайчид нэгдэж байгуулсан. 2012 онд SOTRAMI нь Перуд анх удаа Fairtrade & Fairmined алтны гэрчилгээ авсан уурхай болсон. Fairtrade гэрээтэй үнэт эдлэлийн компаниудад шууд экспорт хийх сувгийг байгуулсан. Ажилчид компанийн хувьцааг эзэмшиж, “нэг гишүүн – нэг санал” зарчмаар гол шийдвэрийг гаргадаг. Fairtrade-ийн нэмэлт premium (кг алт тутамд 2000 ам.долларын

нэмэлт)-ийг уурхайчид өөрсдөө ерөнхий хурал дээр шийдэж,
дэд бүтэц, сургууль, эрүүл мэнд гэх мэтэд зарцуулдаг.

2.2.1.6. Иймд зарим бүтээгдэхүүний нийт хэрэгцээ, орон нутгаасаа хангаж буй хувь хэмжээ болон гаднаас авч буй бүтээгдэхүүний хэмжээг дотоодоосоо хангахад шаардлагатай шинээр бий болох боломжтой ажлын байрны тоо мэдээлэл, холбогдох тооцооллыг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 5. Зарим нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээ хангалтын мэдээлэл

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Холбогдох тооцоолол, мэдээлэл
1	Төмс, хүнсний ногооны хэрэгцээ	Жишсэн хүн амын тоо 54,226, төмс хоногт 120г, хүнсний ногоо хоногт 260г, жилийн хэрэгцээ төмс 2,375.1 тн, хүнсний ногоо 5,146.0 тн, дотоодоос хангаж буй хувь төмс 22 орчим хувь, хүнсний ногоо 11 орчим хувь байна. Шинээр бий болох боломжит ажлын байрны тоо 150-180 орчим.
2	Сүүний хэрэгцээ	Жишсэн хүн амын тоо 54,226, сүү хоногт 160г, жилийн хэрэгцээ 3,167.0 тн, сүүний дотоодоос хангаж буй хувь 58 орчим хувь, шинээр бий болох боломжит ажлын байрны тоо 40-55 орчим.
3	Өндөгний хэрэгцээ	Жишсэн хүн амын тоо 54,226, өндөг хоногт 20г, жилийн хэрэгцээ 396.0 тн, дотоодоос хангаж буй хувь төмс 12.5 орчим хувь, шинээр бий болох боломжит ажлын байрны тоо 20 орчим.
4	Сурагчийн дүрэмт хувцас	2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-ийн сурагч 14.5 мянга, жилийн хэрэгцээт дүрэмт хувцасны иж бүрдэл 9.4 мянга, шинээр бий болох боломжит ажлын байр 35-40 орчим.

2.2.1.7. ЖДҮ, үйлчилгээний хувьд тээвэр, шатахуунгүйгээр үйл ажиллагаа явуулах нь харьцангуй ховор буюу дийлэнх үйлдвэрлэл, үйлчилгээнд тээврийн хэрэгсэл, шатах тослох материалыг өдөр тутамдаа тогтмол хэрэглэдэг. Сүхбаатар аймаг 2024 онд ачааны автомашин, зүтгүүр, чиргүүл зэргийг худалдан авахад нийт 29.7 тэрбум төгрөг зарцуулсан байна. Иймд ялангуяа ачааны зориулалттай тээврийн хэрэгслийн импорт, худалдан авах аймаг, орон нутгийн хэрэгцээгээ үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нар хоршоолсон хуулийн этгээд байгуулах замаар хангах боломжтой байна.

2.2.1.8. Ингэснээр бодит өртгөөр тээврийн хэрэгслийг худалдан авах нөхцөл бүрдэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, өртөг буурах нөхцөл бүрдэхээр байна. Мөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон хэрэглэгч нар шатах тослох материалын нийтлэг хэрэгцээгээ боломжит үнээр, найдвартай хангахын тулд хамтран хоршоолсон хуулийн этгээд байгуулж, шатахууны худалдан авалт, тээвэр, агуулах, нөөц, түгээлтийг хараат бусаар хийх боломжтой байна.

2.2.1.9. Иймд орон нутгийн төр захиргааны байгууллагууд буюу АЗДТГ, сумдын ЗДТГ, ХХААГ, ХХҮГ болон холбогдох бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллага, холбоодын зүгээс хамтын эдийн засгийн ойлголтыг иргэд, олон нийтэд түгээх, таниулах, сургалт, мэдээллийг тогтмол мэдээлж, орон нутагт хоршоолсон үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар үр нөлөөтэй арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.2.1.10. Хоршоолсон эдийн засгийн хөгжлийг дэмжих хүрээнд 2025 онд Сүхбаатар аймагт сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгч 9 хоршоодыг нэгтгэн орон нутагт анх удаа “Мандах наран сүүн далай” дундын хоршоог байгуулсан байна. Тус

хоршоодын 20-25 гишүүнийг НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран 2 удаагийн туршлага судлах аялал, 5 удаагийн зөвлөх үйлчилгээг үзүүлээд байна. Тус дундын хоршоо нь 2025 онд Баруун-Урт суманд шинээр ашиглалтад орсон сүүний үйлдвэрт өдөр бүр 300-350 литр сүүг тогтмол нийлүүлж байна. Цаашид дундын хоршооны түүхий эдийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэр, түүхий эд нийлүүлэгчийн хамтын ажиллагааг кластерын системээр хөгжүүлэх сүүний чиглэлийн фермер байгуулах техник эдийн засгийн үзүүлэлтийг Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой байдлын ландшафт биологийн олон янз байдлын хамаарал төсөлтэй хамтран гүйцэтгэж, төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг 2026 оны төсөвт батлуулсан байна.

2.2.2. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 874 нэгж талбарын 56.6 мянган га газрыг иргэн, хуулийн этгээдэд олгосон байх бөгөөд газар тариалангийн чиглэлээр олгосон 40.1 мянган га газрын 76.8 хувь ашиглалтгүй байна.

2.2.2.1. Сүхбаатар аймаг 82 287.15 км² буюу 8,228,715 га газар нутагтай бөгөөд нийт газар нутгийн 0.69 хувь буюу 56,648 га газрыг эзэмшил, өмчлөлөөр иргэн, хуулийн этгээдэд олгосон байна. Үр тарианы усалгаатай, усалгаагүй тариалан, тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан болон жимс, жимсгэнийн усалгаагүй тариалангийн зориулалтаар олгосон эзэмшлийн газрын хэмжээ 70.8 хувь буюу 40,134 га байна. Аймгийн хэмжээнд 2024 онд эдгээр талбайд тариалалт хийсэн хэмжээг авч үзэхэд 9.3 мянган га байна. Өөрөөр хэлбэл 40.1 мянга га талбайн 23.2 хувьд 2024 онд тариалалт хийсэн буюу 76.8 хувь нь ашиглалтгүй байна.

2.2.2.2. Эдгээр талбайг 10 хуулийн этгээд, 1 төрийн байгууллага, 15 иргэн эзэмшиж байгаа бөгөөд үүнээс Түмэнцогт суманд 37.3 хувь, Сүхбаатар суманд 33.2 хувь, Эрдэнэцагаан суманд 17.4 хувь, Мөнххаан суманд 12.0 хувь, Баяндэлгэр болон халзан суманд 0.1 хувь нь хамаарч байна. Хамгийн их га, талбай эзэмшиж буй иргэн, хуулийн этгээдийг дурдахад Дорнодшим агро ХХК 9,997.2 га, Хосдалбаа ХХК 4,000 га, Номин Богд ХХК 4,000 га, Хэрлэн-Алтай ХХК 3,500 га, Мандах нутгийн тариа ХХК 3,000 га, Бэлчээрийн экологи ХХК 3,000 га, Энгүй тал ХХК 2,000 га, Газрын чимэг ХХК 1,800 га, 2 иргэн 5,290.9 га тус тус эзэмшиж байна.

2.2.2.3. Харин уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж, ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай, уурхайн зориулалтаар олгосон газрын хэмжээ 16.6 хувь буюу 9,430 га байна. Бусад зориулалтаар олгосон газрын хэмжээ 12.6 хувь буюу 7,084 га, үүнээс мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах, ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор, төмс, хүнсний ногооны усалгаатай, усалгаагүй тариалан, жимс, жимсгэнийн усалгаатай тариалан, тэжээлийн ургамлын усалгаатай тариалан болон эрчимжсэн мал аж ахуйн фермийн зориулалтаар нийт 1.5 хувь буюу 855 га газар олгосон байна.

2.2.2.4. Аймгийн хэмжээнд 2025 оны 11 сарын байдлаар 2293 нэгж талбарын газрыг 82 төрлийн зориулалтаар олгосон байх бөгөөд үүнээс үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой 24 төрлийн зориулалтаар 874 нэгж талбарын газар олголт, аль суманд ямар тоо хэмжээтэй байгааг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 5. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар олгосон газрын мэдээлэл

№	Зориулалт	Асгат	Баруун-Урт	Баяндэлгэр	Дарьганга	Мөнххаан	Наран	Онгон	Сүхбаатар	Түвшинчирээ	Түмэнцогт	Уулбаян	Халзан	Эрдэнэцагаан	Нийт дүн
1	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	13	74	47	27	28	13	21	16	27	14	9	3	53	345
2	Төмс, хүнсний ногооны усалгаатай тариалан	4	13			5	1		78		1	1			103
3	ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор	5	7	6	1	5	1		35	3	4	1	17	3	88
4	Төмс, хүнсний ногооны усалгаагүй тариалан		1	4		57			9		1			5	77
5	Шатахуун түгээх газар, агуулах	2	10	3	3	4	2	3	4	3	7	2	1	5	49
6	Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах				1	34							1		36
7	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж			1		4			8		1	7		5	26
8	Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай	1				1			16		1	3		3	25
9	Банк, санхүүгийн байгууллага	2	1	1	2	2	2		2	1	1	2	2		18
10	Мал аж ахуйн үйлдвэрлэл				1				6				7		14
11	Тэжээл, бордооны агуулах	1	1	1		2	1	1	1	2	1	2			13
12	Үр тарианы усалгаагүй тариалан					2					9			2	13
13	Эрчимжсэн мал аж ахуйн ферм								5				7		12
14	Автомашинь засвар, үйлчилгээний газар		3			1			2	1	1			1	9
15	Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан			1					1		6		1		9
16	Жимс, жимсгэний усалгаатай тариалан		1			1			4		1		1		8
17	Жимс, жимсгэний усалгаагүй тариалан								3		2				5
18	Зоорь, ХАА-н бүтээгдэхүүн хадгалах газар		1					1	1		1				4
19	Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар		1			1		2							4
20	Тэжээлийн ургамлын усалгаатай тариалан	2			1						1				4
21	Үр тарианы усалгаатай тариалан								4						4
22	Гаалийн хяналтын талбай													3	3
23	Уурхайн газар					1						2			3
24	Аялал, жуулчлалын бааз								2						2
	Нийт дүн	30	113	64	36	148	20	28	197	37	52	29	40	80	874

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ГХБХБГ

2.2.2.5. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар иргэн, хуулийн этгээдээс газрын цахим системээр 2024-2025 онд гаргасан хүсэлтийн мэдээллийг авч үзэхэд Асгат 10, Баяндэлгэр 3, Дарьганга 4, Мөнххаан 3, Наран 1, Онгон 3, Сүхбаатар 63, Түмэнцогт 3, Уулбаян 5, Халзан 20, Эрдэнэцагаан 14, Баруун-Урт 6, нийт газар эзэмших 135 хүсэлтийг гаргасан байна. Эдгээрийг зориулалтаар ангилж үзэхэд ачаа тээвэр 6, амралт, жуулчны бааз 9, газар тариалан 28, мал аж ахуй 50, орон сууц, барилга 5, худалдаа, үйлчилгээ 21, уул уурхай 4, бусад 12 байна.

2.2.2.6. Баруун-Урт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголд жижиг, дунд үйлдвэрлэл болон үйлчилгээ эрхлэгчдийн хөгжилд шаардлагатай газар зохион байгуулалт, зориулалтын бүсийн тодорхой шийдлүүдийг тусгасан байна. Тухайлбал, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, үйлдвэрлэл-үйлчилгээний зориулалтын шинэ бүсүүдийг төлөвлөх, логистикийн зангилаа хөгжүүлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтөд бизнесийн зориулалтын талбайг багтаах зэргээр ЖДҮ-ийн хэрэгцээнд нийцсэн газар олголт, дэд бүтцийн төлөвлөлтийг нарийвчлан боловсруулжээ. Энэ нь орон нутгийн бизнесийн орчин, ажлын байр, үйлдвэрлэлийн өсөлтийг бодитой дэмжих гол нөхцөлийг бүрдүүлж байна.

2.3. ЖДҮ, үйлчилгээг дэмжих арга хэмжээнүүдийн хэрэгжилт бодит шалгуур үзүүлэлттэй уялдаагүй, тодорхой бус байсан бөгөөд зээлд хамрагдсан байгууллагуудын 69.3 хувь нь нийгмийн даатгалын бүртгэлгүй, ЖДҮХС-ын зээл олгосон ААНБ-ууд шинээр ажлын байр нэмээгүй, заримынх нь ажлын байр буурсан байна.

2.3.1. ЖДҮ, үйлчилгээг дэмжих арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ерөнхий тайлагнаснаар үр нөлөөгүй арга хэмжээнүүдийг өөрчлөх, шинэчлэх, сайжруулах боломжийг алдаж байна.

2.3.1.1. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Сүхбаатар аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны биелэлтийн тайлан, Сүхбаатар аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангаас ЖДҮ, үйлчилгээ дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан үзэхэд биелэлтийг тайлагнахдаа хэрэгжүүлсэн үйл ажиллагаа буюу юу хийснээ тоочсон хэлбэр давамгай, харин үр нөлөө буюу яг аль шалгуур үзүүлэлтийн түвшин яаж эергээр өөрчлөгдсөн талаар тодорхой бус байна.

2.3.1.2. Дараах хүснэгтэд Сүхбаатар аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны биелэлтийн тайлан дахь ЖДҮ, үйлчилгээ дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг батлагдсан шалгуур үзүүлэлттэй нь харьцуулж үзүүлэв.

Хүснэгт 6. ЖДҮ, үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хэрэгжилт

Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес					
№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин 2025 он	АЗДТГ-аас гаргасан 2024 оны хэрэгжилт
1	Шинээр бий болсон ажлын байрны тоо	тоо	867	4000	“Жижиг дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын дагуу зохион байгуулж, нийт 21 аж ахуйн нэгж 2,7 тэр бум төгрөгийн зээлийн хүсэлт цахим системд ирсэн. Зээлийн мэдээллийн цахим системд журмын дагуу 4 шатны үнэлгээ хийгдэж 12 аж ахуйн нэгжид 1,5 тэрбум төгрөгийн зээл олгосон. Хөнгөлөлттэй зээлийн үр дүнд 50 шинэ ажлын байр бий болсон.
2	Ажилгүйдлийн түвшин	хувь	7.6	6.5	
3	Ядуурлын түвшин	хувь	30.2	20	
4	ЖДҮ-г дэмжихээр олгосон хөнгөлөлттэй зээлийн хэмжээ	сая. төг	1100	7000	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Сүхбаатар аймгийн хэмжээнд 252 хоршоо шинээр байгуулагдаж 184 хоршооны 492 малчинд 15,0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон байна. Үүний үр дүнд малчид хоршоо болон нэгдэж эрчимжсэн аж ахуйн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Мөн эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 9 хоршоо нэгдэж "Мандах наран сүүн далай" дундын хоршоог үүсгэн байгуулсан. "Сүхбаатар хөгжил ҮТП" ОНӨААТҮГазрын жижиг дунд үйлдвэрлэлийн нэгдүгээр бүсэд улсын
5	Бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг, тусалцааны тоо, хамрагдагсдын тоо	тоо	10/250	70/1500	
6	Бизнесийн салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо	тоо	836	1200	

**Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж
буй бодлогын хэрэгжилт, үр дүн**

7	Кластерын системээр үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчид, хоршоодын тоо /Кластерын нийт тоо/	тоо	0	5	төсвийн 700,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хоногт 500-1000 литр сүү боловсруулах сүүний үйлдвэрийн барилгыг 2024 онд орон нутагт хүлээж авсан. Тус үйлдвэрийг тоног төхөөрөмжийг НҮБ-ийн хөдөө аж ахуйн тогтвортой газартай хамтран орон нутаг шийдвэрлэхээр 2025 онд төсөвт 160,0 сая төгрөг баталж, техникийн тодорхойлолтыг боловсруулж байна. Тус сүүний үйлдвэрийг үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дундын хоршооны кластерын системд суурилан хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.
8	Мэргэжлийн сургалтад хамрагдсан иргэдийн байнгын ажлын байранд зуучлагдсан хувь	хувь	37.1	70	Аймгийн хэмжээнд 2021-2024 онд бүртгэлтэй ажил хайгч 168 иргэнийг мэргэжил олгох сургалтад хамруулж 95 иргэн байнгын ажлын байртай болсон. Үүнд Үсчин гоо сайхны сургалт 37 иргэн, Оёдлын сургалт 15, Авто засвар, 18, Хүнд машин механизмын операторч 20, нярав 16, тогооч 19, Цахилгаанчин мэргэжлээр 19 ажилгүй иргэн, талх нарийн боов үйлдвэрлэл мэргэжлээр 27 иргэнийг хамруулсан.
9	МСҮТөв төгсөгчдөд ажил эрхэлж байгаа төгсөгчдийн эзлэх хувь	хувь	67.5	80	
10	Мэргэжлийн зэрэг ахиулах сургалтын тоо	тоо	-	3	
11	Хөдөлмөр эрхлэх санал, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний тоо	тоо	4	15	2021-2024 онд Хөдөлмөрийн насны иргэдийг Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт болон суурь ур чадвар олгох сургалт, Старт ап арга хэмжээнд хамруулж тэднийг өрхөөр үйлдвэрлэл эрхлэхэд хүсэлтэй 136 иргэнд ажлын байртай болоход нь зориулж 1.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгож 145 ажлын байр шинээр бий болсон. Мөн албан байгууллага аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу 2644 иргэнийг ажилд зуучилсан.
12	Байнгын ажлын байранд зуучлагдсан зорилтот бүлгийн иргэдийн тоо	тоо	47	150	
13	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	хувь	36.9	32	

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗДТГ

2.3.1.3. Сүхбаатар аймагт жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийг тайлагнахдаа батлагдсан шалгуур үзүүлэлттэй уялдуулан хэмжих, харьцуулах боломжтой хэлбэрээр тайлагнах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл 3-4 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнаж байгаа нь хэрэгжилтийг тодорхой бус тайлагнаж байгааг илтгэн харуулж байна. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан ЖДҮ, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг холбогдох шалгуур үзүүлэлттэй харьцуулан бодитой тайлагнаснаар аль арга хэмжээ нь үр дүнтэй, үр дүнгүй байгаа нь тодорхой харагдаж, үр нөлөөгүй арга хэмжээг хэрэгжүүлэхээ зогсоож, дараагийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх уян хатан шийдвэр гаргах нөхцөл бүрдэнэ. Арга хэмжээнүүдийн биелэлтийг хэт ерөнхий тайлагнаснаар үр нөлөөгүй арга хэмжээнүүдийг өөрчлөх, шинэчлэх, сайжруулах боломжийг алдаж байна.

2.3.2. ЖДҮ, үйлчилгээг дэмжих зорилгоор олгосон 4 төрлийн зээлд хамрагдсан 254 ААНБ-ын 12 нь татварын, 176 нь нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлгүй байсан бөгөөд ЖДҮХС-аас 2024 онд зээл авсан 14 ААНБ нийт 55 шинэ ажлын байр нэмэх үүргээ биелүүлээгүй, харин өмнөх ажлын байр 5-аар буурсан байна.

2.3.2.1. Сүхбаатар аймагт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зорилгоор 2023-2025 онд жил бүр орон нутгийн төсөв 300.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг баталсан байна. Тус санхүүжилтийн эх үүсвэрийг жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд төвлөрүүлж, зээл олгох зориулалт, хэмжээ, хүү, хугацааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Аймгийн Засаг дарга нарын “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ”-нд заасанчлан жилийн тогтмол 3 хувийн хүүтэй, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа 12 сар хүртэл хугацааг оролцуулан нийт 60 сар байхаар хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон байна.

2.3.2.2. Хоршоо хөгжүүлэх сангаас 2011 оноос 2025 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 637 төслийг сонгон шалгаруулж иргэн, хуулийн этгээдэд нийт 7.7 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд одоогоор 2.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 100 зээлдэгчийн 856.0 сая төгрөгийн зээл хугацаа хэтрэлттэй байна. Сумдын 2024 оны төсвөөс авч үзэхэд хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгохоор баталсан хөрөнгө нийт 2,165.0 сая төгрөг байх боловч гүйцэтгэлээр 155.0 сая төгрөг буюу батлагдсан хөрөнгийн 7.1 хувийг нийт 4 хоршоодод зээл олгосон байна.

2.3.2.3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2020–2025 онуудын хооронд нийт 38 аж ахуйн нэгжид зээл олгосноос 3 аж ахуйн нэгжийн зээл хаагдаж, 2025 оны 11 сарын байдлаар 35 аж ахуйн нэгжийн 3.2 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн зориулалтаар нь ангилж авч үзэхэд 39.3 хувь нь мал аж ахуйн үйлдвэрлэл, 14.4 хувь нь мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 13.1 хувь нь үйлчилгээний салбар, 6.2 хувь нь сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үлдсэн хувь нь хүнсний бүтээгдэхүүн, оёмол бараа болон бусад үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар зээл олгосон байна.

2.3.2.4. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Сүхбаатар аймагт 2024-2025 онд 174 хоршоонд 22.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Тус хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийг зориулалтаар нь ангилж үзэхэд 56.5 хувь нь үржлийн мал худалдан бойжуулах, борлуулах чиглэлээр 13.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байх бөгөөд холбогдох мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 7. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн мэдээлэл (сая төгрөг)

№	Зээлийн зориулалт	Төслийн тоо	Мөнгөн дүн
1	Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн үйлдвэрлэл, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	16	908.0
2	Үржлийн мал худалдан бойжуулах, борлуулах	186	13,917.0
3	Мал бордох аж ахуй байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	16	902.0
4	Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник, тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх, технологи нэвтрүүлэх	11	573.0
5	ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах, үйлдвэрлэлийн зориулалттай барилга, байгууламж барих, өргөтгөх, засварлах, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, (автомашин), тоног төхөөрөмж худалдан авах	34	1,632.5
6	Мах, сүү, цагаан идээ бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	37	2,805.0

<i>Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилт, үр дүн</i>			
7	Бэлчээрт худаг, уст цэг гаргах, усан хангамж байгуулах	12	400.5
8	Мал төхөөрөх цех, үйлдвэр байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	10	969.0
9	Мал, малын гаралтай түүхий эдийн агуулах, зоорь, хөргүүр байгуулах	5	260.0
10	Ноос, ноолуур, арьс шир бэлтгэх, анхан шатны тордолт хийх цэг, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	1	30.0
11	Дотор мах боловсруулах үйлдвэр, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	1	235.0
Дүн		329	22,632.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ХХААГ

2.3.2.5. Хүнсний хувьсгал үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар аймагт 19 иргэн, ААНБ-д 15.8 тэрбум зээл олгосон байна. Тус хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийг зориулалтаар нь ангилж дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 8. Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн мэдээлэл (сая төгрөг)

№	Зээлийн зориулалт	Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)
1	Хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих /5.7.3/	6	8,380.00
2	Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд зээл, зээлийн хүүгийн дэмжлэг	2	3,000.00
3	Хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих	3	850
4	Орон нутагт сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хэрэглээнд зориулан хүнсний үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх	1	100
5	Хүнс, газар тариалан (үр тариа)-гийн техник тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	1	300
6	Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд зээл, зээлийн хүүгийн дэмжлэг /5.2.4/	1	2,000.00
7	Хүнс, газар тариалан (үр тариа)-гийн техник тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	1	80
8	Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд зээл, зээлийн хүүгийн дэмжлэг	1	80
9	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчийн эргэлтийн хөрөнгийг сайжруулах	3	981
Дүн		19	15,771.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ХХААГ

2.3.2.6. Дээрх хөнгөлөлттэй зээлд хамрагдсан ААНБ-ууд татвар болон нийгмийн даатгалын байгууллагуудад бүртгэлтэй эсэхэд дүн шинжилгээ хийж үзэхэд 254 хуулийн этгээдээс 12 нь татварын байгууллагад бүртгэлгүй, 176 хуулийн этгээд нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлгүй байна. Хөнгөлөлттэй зээлийн төрлөөр ангилж дараах хүснэгтээр харууллаа.

**Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж
буй бодлогын хэрэгжилт, үр дүн**

Хүснэгт 9. Хөнгөлөлттэй зээлд хамрагдагчдын татвар, НД-ын бүртгэл

№	Хөнгөлөлттэй зээлийн төрөл		Зээлдэгч ААНБ-ын тоо	Татварт бүртгэлтэй эсэх		Нийгмийн даатгалд бүртгэлтэй эсэх	
				Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1	Хүнсний хөтөлбөр	хувьсгал	15	12	3	11	4
2	ЖДҮ-ийг хөгжүүлэх сан		34	33	1	31	3
3	Сумдын хөгжүүлэх сан	хоршоо	31	31	0	19	12
4	Шинэ хөдөлгөөн	хоршоо	174	166	8	17	157
Дүн			254	242	12	78	176

2.3.2.7. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас 2024 онд олгосон 14 төслийн зээлдэгч ААНБ-уудын нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй эсэх, төсөл тусгасан ажлын байрыг бий болгосон эсэхэд дүн шинжилгээ хийхэд 79 ажлын байр бий болохоос нийгмийн даатгалын тайлангаар баталгаажсан 19 ажлын байр буюу 24 хувьтай байна. Мөн энэхүү 19 ажлын байр нь төсөл шалгарах үеийн 24 ажлын байрнаас буурсан байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл зээлийн хүрээнд шинээр ажлын байр бий болох байтал буурсан дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 10. ЖДҮХС-аас 2024 онд зээл авсан ААНБ-уудын бий болгосон ажлын байрны мэдээлэл

№	Зээлдэгчийн нэр	Зээлийн зориулалт	Төсөлд тусгасан ажлын байрны мэдээлэл			Нийгмийн даатгал төлдөг ажилтны тоо
			Хадгалах ажлын байр	Шинээр бий болгох	Нийт ажлын байрны тоо	
1	Цахим баавай ХХК	Үйлчилгээ	2	2	4	2
2	Ашид баян арвижих дүүрэн ХХК	Мал аж ахуй	1	4	5	1
3	Дагшин оюу ХХК	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2	5	7	2
4	Ханшорвог ХХК	Үйлчилгээ	1	4	5	1
5	Бугат аав ХХК	Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4	4	8	4
6	Арга түшиг ХХК	Мал аж ахуй	1	2	3	1
7	Аримун луу ХХК	Үйлчилгээ	1	9	10	1
8	Ган ирээдүйн оргил ХХК	Үйлчилгээ	1	5	6	Бүртгэлгүй
9	Үлэмж Дүүрэн Мишээл ХХК	Гурилын үйлдвэр	1		1	Бүртгэлгүй
10	Далайцагаан нуур ХХК	Үйлчилгээ	1	9	10	Бүртгэлгүй
11	Жигүүр Ундрага ХХК	Мал аж ахуй	4	5	9	3
12	Миний өөшгөө ХХК	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1	1	2	Бүртгэлгүй
13	Аздэлгэр мөнх хоршоо	эрчимжсэн аж ахуй	0	0	0	Бүртгэлгүй
14	Түмэн цагаан ноос хоршоо	Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4	5	9	4
Нийт дүн			24	55	79	19

2.3.2.8. Дээрх ААНБ-ууд нь төрөөс хөнгөлөлттэй зээл авсан хэдий боловч бодитоор ажлын байр бий болгож чадахгүй байгаагийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж дүгнэлээ. Тодруулбал зээл авсан ААНБ-ууд нь 1-2 эзэмшигчтэй, аж ахуй эрхлэх үр чадвар, мэдлэг дутагдах, тогтвортой хэрэглэгч байхгүй зэрэг нь тухайн төслүүдийн бодит хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Иймд орон нутагт хамтын эдийн засгийн талаарх ойлголтыг олон нийтийн дунд бий болгож, хэрэглэгч нь эзэн, мөн нийлүүлэгч нь эзэн загвараар хоршин ажилладаг хэдэн зуу, хэдэн мянган гишүүнчлэлтэй хоршоолсон хуулийн этгээдүүдийг бий болгож, хөгжүүлснээр төрөөс олгож буй хөнгөлөлттэй зээлийн үр нөлөө эрс дээшилж, тогтвортой хуулийн этгээд бий болж, нийгмийн баталгаа нь хангагдсан найдвартай ажлын байр олноор бий болох бодит боломж байна.

2.3.2.9. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зарцуулалт, төслийн хэрэгжилтийг хянахдаа чеклист буюу хяналтын хуудас боловсруулж хяналт тавих шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл төслийн төлөвлөсөн түвшнийг бодит гүйцэтгэлтэй харьцуулах хүснэгтэн хэлбэрийн хяналтын хуудас байх шаардлагатай. Тодруулбал сүүний фермерийн төслийн хувьд хэдэн үнээ авах, хэдэн үнээний байр барих, ямар хүчин чадлын цахилгаан эрчим хүч татах, гүний худаг гаргах эсэх, хэдэн ажлын байр бий болгох зэрэг тухайн төслийн хүчин чадал, эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг хяналтын хуудаст шалгуур болгон тусгаж, улмаар бодит гүйцэтгэлийг харьцуулан бүртгэж, хяналт тавих нь хяналтын үр нөлөөг дээшлүүлэхээр байна.

2.3.2.10. Зээлдэгч нараас улирал тутамд ирүүлэх тайланд хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтыг тодорхой болгож, хяналт хэрэгжүүлэхэд ойлгомжтой байх үүднээс төсөл тус бүрд тусгайлан төслийн данстай байхыг шаардах нь зүйтэй. Улмаар тухайн дансны хуулга, худалдан авалтын цахим баримт, байгуулсан гэрээ болон бусад шаардлагатай холбогдох материалыг, төслийн үр дүнгийн тайлангийн хамт улирал тутамд авч, хяналтын хуудас тэмдэглэл үйлдэж, төслийн хэрэгжилт, хяналтын материалыг нэгтгэн архивын хадгаламжийн нэгж үүсгэн архивд тухай бүр шилжүүлж байх шаардлагатай байна.

2.3.2.11. ЖДҮ-ийн төслийн зээлийн санхүүжилтийг төслийг хэрэгжүүлэх үе шатны хуваариар хэсэгчлэн олгох асуудлыг цаашид судлан, шийдвэрлэх хэрэгцээтэй байна. Учир нь төсөл хэрэгжүүлэгч төслийн санхүүжилтийг нэг дор бүгдийг нь авснаар санхүүжилтийг зориулалтын бус зарцуулах эрсдэл бий болгох сөрөг үр дагаврыг дагуулж байна.

2.3.2.12. Сүхбаатар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргын харьяаны дотоод аудит буюу Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь 2025 оны 10 дугаар сард ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зориулалт, эргэн төлөлтийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна. Тус шалгалтаар 2023-2024 онд зээл олгосон төслүүдээс 13 төслийн хэрэгжилтийг газар дээр очиж, хянаад 5 төслийн хэрэгжилт удаашралтай төслийн үе шатны дагуу хэрэгжээгүй, 2 төсөл хэрэгжээгүй зөрчлийг илрүүлж, зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй аж ахуй нэгж байгууллагын зээлийг татан төвлөрүүлэх, хүү алдангийг төлүүлэх албан шаардлага өгч, Жижиг дунд үйлдвэрийн газарт хяналтыг сайжруулах санал хүргүүлсэн байна.

2.3.3. Хамтын эдийн засгийн талаарх ойлголт, мэдээллийг хуваалцах, түгээх чиглэлээр уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг иргэд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн дунд тогтмол зохион байгуулж эхлэх шаардлагатай байна.

2.3.3.1. Сүхбаатар аймгийн хэмжээнд 2024 онд орон нутгийн бизнес эрхлэгчдийн чадавхыг сайжруулах, бараа бүтээгдэхүүний сурталчилгаа, борлуулалтыг нэмэгдүүлэх, туршлага солилцох зорилгоор дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна. Үүнд:

- Орон нутгийн бизнес эрхлэгчдийн хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, үзэсгэлэн худалдаа болон уралдаан тэмцээнүүдэд оролцуулах, дотоод-гадаад туршлага судлуулах зорилгоор 15 удаагийн арга хэмжээнд 500 гаруй бизнес эрхлэгчийг хамруулсан.
- 2024 онд орон нутгийн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Цагаан сарын үзэсгэлэн, “Сүхбаатарт үйлдвэрлэв-2024”, “Эрүүл хүнс”, “Алтан намар”, “Хөнгөн үйлдвэрлэл”, “Шилмэл мал”, “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль, хоол үйлдвэрлэл болон үсчин-гоо сайханчдын улсын, бүсийн тэмцээн зэрэг 9 арга хэмжээнд 450 төлөөлөгчийг оролцуулж, туршлага судлуулах аялал зохион байгуулсан.
- 2024 оны 09 сарын 20–21-нд Баруун-Урт суманд зохион байгуулсан “Эрүүл хүнс”, “Алтан намар”, “Хөнгөн үйлдвэрлэл”, “Шилмэл мал” үзэсгэлэнд 12 сумын 184 малчин, иргэн, ААН оролцож, нийт 248 сая төгрөгийн борлуулалт хийсэн.
- Монголын Аялал жуулчлалын холбооны зохион байгуулсан “International Travel Mart 2024” үзэсгэлэнд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд бүсчлэн нэгдсэн талбайгаар хамтран оролцсон нь онцлог байв. ЗДТГ, СУАЖГ, Залуучуудын төв болон орон нутгийн брэндүүд нийлж 7–8 төрлийн 100 гаруй бүтээгдэхүүн, 600 гаруй тараах материалтай оролцож, туршлага солилцох, түншлэл хөгжүүлэх олон боломжийг бүрдүүлсэн.

2.3.3.2. Шинэ хоршоо хөдөлгөөний үр дүнд орон нутагт шинээр бий болсон хоршоодын хөгжлийг тогтвортой хангах, хамтын эдийн засгийн талаарх ойлголтыг орон нутагт нутагшуулах, хоршоодыг чадавхжуулах хүрээнд холбогдох төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран 2025 онд хоршоодын 45 төлөөллийг дотоодод туршлага судлах аялал, 120 төлөөллийг зөвлөх үйлчилгээнд хамруулж ажилласан байна.

2.3.3.3. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, бодит утгаар дэмжих зорилгоор хамтын эдийн засгийн (хоршоо, хамтын бизнес, олон нийтийн оролцоонд суурилсан эдийн засаг) ойлголтыг олон нийт, аж ахуйн нэгж, иргэдэд түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг системтэй зохион байгуулах шаардлагатай байна. Үүнд: хамтын эдийн засгийн талаарх уулзалт, зөвлөгөөн-хэлэлцүүлэг, сургалт, мэдээллийн өдөрлөг тогтмол зохион байгуулах; энэ чиглэлээр мэргэшсэн сургалтын байгууллага, судлаач, зөвлөхүүдийг урьж оролцуулан бодит жишээ, арга зүйгээр мэдлэг, ойлголт олгох; цаашид орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөнд дээрх ажлуудыг тусган, хэрэгжилтэд шаардлагатай санхүүжилт, хариуцагч, хугацаа, шалгуур үзүүлэлт тодорхойлон хэрэгжүүлэх нь зүйтэй.

---o0o---

Холбогдох байгууллагын санал:



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Сүхбаатар, Баруун-Урт, 7-р баг, Нутгийн удирдлагын
ордон

Утас: 70518585, Факс: 70518585

Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn

Цахим хуудас: Sukhbaatar.gov.mn

2025.12.16 № 05/1522

танай _____-ны № _____-т

Г СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Г Хариу хүргүүлэх тухай Г

Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодоогын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлантай танилцлаа. Тайлантай холбоотой төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж байгаа бодлого, эрх зүйн орчны нөлөөллөөс хэрэгжүүлэх боломжгүй зарим арга хэмжээнд тайлбар хүргүүлж байна.

1. Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг төрөөс дэмжих чиглэлүүдийн нэг болох шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах арга хэмжээ дурдсан байна. Үүний хүрээнд орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зорилгоор 2023-2025 онд жил бүр орон нутгийн төсвөөс 300,0 (гурван зуун сая) төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг баталж байна. Тус санхүүжилтийн эх үүсвэрийг жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд төвлөрүүлж, зээл олгох зориулалт, хэмжээ, хүү, хугацааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Аймгийн Засаг дарга нарын “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ”-нд заасанчлан жилийн тогтмол 3 хувийн хүүтэй, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа 12 сар хүртэл хугацааг оролцуулан нийт 60 сар байхаар хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож байна.

2. Орон нутагт хямд түрээсийн өртөгтэй ажлын байр барих зөвлөмжийн хүрээнд үйлдвэр эрхлэгчдийг хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Сүхбаатар хөгжил УТП” ОНӨААТҮГазар нь 2017 оноос хойш тасралтгүй ажиллаж байна. Тус байгууллагын бизнес инкубатор төвд одоогийн байдлаар 7 иргэн, аж ахуй хөнгөлөлттэй нөхцөлөөр бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байна. Бизнес эрхлэгчид өргөжиж чадахгүй байгаа нэг шалтгаан нөхцөл нь аж ахуй нэгжийн орон нутгийн дулааны төлбөр өрхийн хэрэглэгчдээс 5-6 дахин их байгаа нь хүндрэл үүсгэж байгаа учир хямд зардлаар, эдийн засгийн үр өгөөж өндөр, нарны эрчим хүчээр дулаан, цахилгааны асуудлыг шийдвэрлэсэн бизнес инкубатор төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлд суурьлан байгуулахаар худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран зураг, төсвийг

боловсруулж батлуулаад байна.

3.Хоршоолсэн эдийн засгийн хөгжлийг дэмжих хүрээнд 2025 онд Сүхбаатар аймагт сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгч 9 хоршоодыг нэгтгэн орон нутагт анх удаа “Мандах наран сүүн далай” дундын хоршоог байгуулсан. Тус хоршоодын 20-25 гишүүнийг НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран 2 удаагийн туршлага судлах аялал, 5 удаагийн зөвлөх үйлчилгээг үзүүлээд байна. Тус дундын хоршоо нь энэ онд Баруун-Урт суманд шинээр ашиглалтанд орсон сүүний үйлдвэрт өдөр бүр 300-350 литр сүүг тогтмол нийлүүлж байна. Цаашид дундын хоршооны түүхий эдийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэр, түүхий эд нийлүүлэгчийн хамтын ажиллагааг кластерын системээр хөгжүүлэх сүүний чиглэлийн фермер байгуулах техник эдийн засгийн үзүүлэлтийг Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой байдлын ландшафт биологийн олон янз байдлын хамаарал төсөлтэй хамтран гүйцэтгэж, төлсийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг 2026 оны төсөвт батлуулаад байна.

4.Шинэ хоршоо хөдөлгөөний үр дүнд орон нутагт шинээр бий болсон хоршоодын хөгжлийг тогтвортой хангах, хамтын эдийн засгийн талаарх ойлголтыг орон нутагт нутагшуулах, хоршоодыг чадавхжуулах хүрээнд холбогдох төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран 2025 онд хоршоодын 45 төлөөллийг дотоодод туршлага судлах аялал, 120 төлөөллийг зөвлөх үйлчилгээнд хамруулж ажилласан. Цаашид хоршоодын төлөөллийг гадаадад туршлага судлах арга хэмжээнд үе шаттай хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

5.Төсвийн тухай хуулиар ААНОАТ нь Улсын төсвийн орлого бөгөөд 40 хувь нь аймгийн төсөвт төвлөрдөг. Төсвийн орлогын төлөвлөлт бааз татварын хэлтэс дээр төвлөрдөг. Улс, аймагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийн салбарыг орон нутагт байгуулахаар том татвар төлөгч багасах, татвараас зайлсхийх хуулийн цоорхой гарах учир ААНОАТ-ыг улсад төвлөрүүлж, аймагт дахин хуваарилдаг. Иймд хууль эрх зүйн хүрээнд өөрчлөлт оруулахгүй бол дээрх заалт орон нутагт хэрэгжих боломжгүй юм.

6.Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ ажлын байр нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээний бодит шалгуур үзүүлэлт, хэмжигдэхүйц үр дүнгийн талаарх алдаа дутагдлыг арилгах, оновчтой тодорхойлох хүрээнд холбогдох мэргэжлийн арга зүйг тогтмол авч оновчтой төлөвлөлтийг хийх тал дээр анхаарал хандуулан ажиллаж байна.



Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
Хэлтсийн дарга
Гомбожав Мөнхзаяа
2025-12-16 17:10:00



СҮХБААТАР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

Боловсролын гудамж 105, Баруун-Урт сум, 1-р баг,
Сүхбаатар аймаг 22087

Утас: 70518032, Факс: 70518032

Цахим шуудан: info@sukhbaatar.hudulmur-halamj.gov.mn

Цахим хуудас: <https://www.gov.mn/mn/organization/sba-halamj>

2025.12.15 № 01/487

танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

“Жижиг, дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд үндэслэн хөдөлмөр, халамжийн чиглэлээр дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Ажил олоход хүндрэлтэй иргэдийн мэдээллийн нэгдсэн санг сайжруулах тухай

Ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэлийг регистрийн дугаарт суурилсан. Нийгмийн даатгалын байгууллагын мэдээлэлтэй уялдуулсан, давхардалгүй, бодит мэдээлэлд тулгуурласан нэгдсэн цахим мэдээллийн сан хэлбэрээр бүрдүүлж, тогтмол шинэчилдэг тогтолцоо би болгох шаардлагатай байна.

Халамжийн арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн бодит үр дүнд суурилуулах

Халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн үр дүнг иргэн бодитоор ажлын байранд орсон эсэх, Нийгмийн даатгал төлж эхэлсэн эсэх, 6-12 сар тогтвортой ажилласан эсэх зэрэг үр дүнгийн шалгуураар үнэлэх, зөвхөн хамрагдсан т оонд бус бодит хөдөлмөр эрхлэлтийг гол үзүүлэлт болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Ажлын байр бий болгосон эсэхийг нийгмийн даатгалын мэдээллээр баталгаажуулах:

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хүрээнд шинээр бий болсон, хадгалагдан үлдсэн ажлын байрны тоог нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтөөр баталгаажуулж тооцдог механизмыг нэвтрүүлэх нь бодит үр дүнг тодорхойлох ач холбогдолтой байна.

Ил тод тайлагнал, дүн шинжилгээний тогтолцоо бүрдүүлэх жил бүр халамжаас хөдөлмөрт шилжсэн иргэдийн тоо:

Хөдөлмөр эрхлэлтийн бодит үр дүн, төсвийн зарцуулалт ба үр ашгийн харьцаа дээр нэгдсэн тайлан, дүн шинжилгээ хийж, олон нийтэд ил тод мэдээлдэг тогтолцоог бүрдүүлэхийг санал болгож байна.

Сургалт, дэмжлэгийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт:

Арга хэмжээг орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн бодит эрэлт, аж ахуйн нэгж, ЖДҮ-ийн хүний нөөцийн хэрэгцээтэй уялдуулж зохион байгуулан, сургалтын дараах ажлын байрны баталгааг хангах шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт:

Хөдөлмөр, халамжийн бодлогыг халамжид хамрагдсан иргэдийн тоонд бус, бодит ажлын байр бий болсон, тогтвортой хөдөлмөр эрхлэлтэд шилжсэн үр дүнд суурилсан тогтолцоонд шилжүүлэх нь зүйтэй байна.



Сүхбаатар аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний
газар
Удирдлага
Дарга
Өлзийсайхан Бат-Амгалан
2025-12-15 15:20:57



СҮХБААТАР АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

107 тоот, боловсрол гудамж, 1 дүгээр баг, Баруун-Урт сум,
Сүхбаатар аймаг 22087, Утас: (976) 70518382
Цахим шуудан: hhaag@sukhbaatar.gov.mn
Цахим хуудас: http://su.hhaag.gov.mn

дддс. 1д. 15. № 1/234
танай дддс. 1д. 12 -ны № 567. -т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

2.3.2.1. Хоршоо хөгжүүлэх сангийн журамд өөрлөлт оруулах

- хоршоонд тавигдах шаардлагыг өөрчлөх /санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын тодорхойлолтыг хасах/

2.3.2. 8. Хүнс, хөдөө аж ахуйн газарт ЖДҮХСан болон Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зарцуулалт, төслийн хэрэгжилтийн явцад хяналт хийхэд шаардагдах зардлыг аймаг, Жижиг дунд үйлдвэрийн газраас шийдэж өгөх.



ДАРГА

ТАГАН-ОЧИР

D:/My doc/blank A5

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

“Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал авахаар 2025.12.12-ны өдөр Сүхбаатар аймгийн ЗДТГ, ХХААГ, ХХҮГ-т тус тус хүргүүлсэн бөгөөд 2025.12.15, 2025.12.26-ны өдрийн 05/1522, 1/234, 01/487 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Ирүүлсэн санал, тайлбарт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр АЗДТГ-аас ирүүлсэн 1-4 саналыг аудитын тайланд (1-р саналыг 2.3.2.1-д, 2-р саналыг 1.2.2.4-т, 3-р саналыг 2.2.1.10-т, 4-р саналыг 2.3.3.2-т) тусгаж, өөрчлөлт оруулав, бусад асуудлын хувьд аудитын зарим дүн, дүгнэлттэй холбоотой тайлбар ирүүлсэн байх тул аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагууд шинээр ажлын байр бий болгож чадахгүй байгаа асуудлыг хамтын эдийн засгийн зарчмаар шийдвэрлэх боломжтой байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хүнс, барааны зах барих, мөн өрхийн бичил үйлдвэрлэл эрхлэгч нарт зориулсан хямд түрээстэй ажлын байр барих боломжтой байна.
3. Орон нутгийн төсвийн зарлага, төрийн худалдан авалтын 25.8 хувийг аймгийн татвартай харьцдаг ААНБ-ууд, 74.2 хувийг бусад аймаг болон нийслэлд бүртгэлтэй ААНБ-ууд ханган нийлүүлж байх бөгөөд орон нутаг зам, барилгын ажлын тендерийн ажлыг гүйцэтгэх чадамжтай хоршоолсон барилгын хуулийн этгээд бий болох боломжтой байна.
4. Хамтын эдийн засгийг орон нутагт бий болгож, дэмжсэнээр үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар олгосон газрын ашиглалт сайжирч, тээвэр логикийн өртөг буурч, хэрэглэгч, нийлүүлэгч нь эзний зарчмаар шийдвэр гаргалтад оролцдог болж, аймгийн дотоодын хэрэгцээг хангах чадамжтай, санхүүгийн хувьд тогтвортой ААНБ-ууд бий болохоор байна.
5. Улс, орнуудын туршлагаас үзэхэд орон нутгийн иргэд нь хоршоолсон хуулийн этгээд байгуулах замаар бүх төрлийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний үйл ажиллагааг эрхэлж, ажилтай орлоготой болж, дундаж давхаргыг нэмэгдүүлдэг жишгийг нэвтрүүлэх боломжтой байна.
6. ЖДҮ, үйлчилгээг дэмжих арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг бодит шалгуур үзүүлэлттэй уялдуулахгүйгээр тодорхой бус тайлагнасан, зээлд хамрагдсан байгууллагуудын 69.3 хувь нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлгүй, ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас зээл авсан ААНБ-ууд нь шинээр ажлын байр бий болгоогүй, өмнөх ажлын байр нь буурсан байна.
7. Төрөөс хөнгөлөлттэй зээл авсан ААНБ-уудын ихэнх нь 1–2 эзэмшигчтэй, аж ахуй эрхлэх мэдлэг-ур чадвар дутмаг, баталгаатай хэрэглэгчгүй зэрэг нөхцөлөөс шалтгаалан төслийн хэрэгжилт бодитоор хангагдахгүй, улмаар ажлын байрны тогтвортой өсөлт, нийгмийн баталгаатай найдвартай ажлын байр бий болох үр нөлөө сул хэвээр байгаа тул хэрэглэгч нь эзэн, нийлүүлэгч нь эзэн буюу хамтын эдийн зарчимд суурилсан олон гишүүнчлэлтэй хоршоолсон хуулийн этгээдийг орон нутагт төлөвшүүлж хөгжүүлэх нь зээлийн үр ашгийг нэмэгдүүлж, ажлын байр бодитоор бий болохоор байна.

8. Олон гишүүнтэй хоршоолсон хуулийн этгээдийг дэмжих бодлого орон нутгийн хөгжлийн баримт бичгүүдэд тодорхой тусгагдаагүй нь хамтын эдийн засагт суурилсан олон гишүүнтэй бизнесийн загвар, кластер хөгжөөгүйд нөлөөлж байх бөгөөд орон нутгийн дотоодын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна.
9. Хамтын эдийн засгийн талаарх ойлголт, мэдээллийг хуваалцах, түгээх чиглэлээр уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг иргэд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн дунд тогтмол зохион байгуулж эхлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст:

1. Хамтын эдийн засгийн талаарх уулзалт, зөвлөгөөн-хэлэлцүүлэг, сургалт, мэдээллийн өдөрлөг тогтмол зохион байгуулах; энэ чиглэлээр мэргэшсэн сургалтын байгууллага, судлаач, зөвлөхүүдийг урьж оролцуулан бодит жишээ, арга зүйгээр мэдлэг, ойлголт өгөх арга хэмжээг хэрэгжүүлэх.
2. Хоршоолсон эдийн засаг буюу хамтын эдийн засаг хөгжсөн улс, орнуудад орон нутгийн төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүд, ТББ, холбоодын төлөөллийг туршлага судлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх.
3. Орон нутгийн төр захиргааны байгууллагууд олон гишүүнтэй хэрэглэгч ба эзэн, нийлүүлэгч ба эзний зарчмаар ажилладаг хоршоолсон хуулийн этгээдүүдийг дэмжих тал дээр түлхүү анхаарч, энэ чиглэлээр үр нөлөөтэй арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлж ажиллах.

Хүнс, хөдөө аж ахуйн газарт:

1. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зарцуулалт, төслийн хэрэгжилтийг хянахдаа чеклист буюу хяналтын хуудас боловсруулж тухайн төслийн хүчин чадал, эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг шалгуур болгон бодит хэрэгжилттэй харьцуулан хяналт тавьж, хяналтын үр нөлөөг дээшлүүлэх.
2. Зээлдэгч нараас улирал тутам тайланг гаргуулан авах, хяналт хэрэгжүүлэхэд ойлгомжтой байх үүднээс төсөл тус бүрд тусгайлан төслийн данстай байхыг шаардах, хяналтын материалыг нэгтгэн архивын хадгаламжийн нэгж үүсгэн архивд тухай бүр шилжүүлж байх.

Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт:

1. Ажил олоход хүндрэлтэй иргэдийн жагсаалтыг регистр суурьтайгаар бүрдүүлж, улмаар нийгмийн даатгалын байгууллагын шимтгэл төлөлтийн дэлгэрэнгүй мэдээллийн сангаас хайлт, шүүлт хийж, жил бүр дүн шинжилгээ хийж ажиллах.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

1. Хамтын эдийн засаг хөгжсөн улс, орнуудын хоршоолсон хуулийн этгээдийг татварын бодлогоор дэмждэг байна. Тухайлбал Испани, АНУ-д хоршооны гишүүдэд хуваарилсан ашиг болон хоршооллыг хөгжүүлэх санд шилжүүлсэн зардлыг татвар ногдох орлогоос хасаж тооцох буюу ашгийн татварыг бага ногдуулдаг сайн жишгийг манай улсад нэвтрүүлэх боломжийг судалж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад уламжлуулах саналыг гаргаж байна.

Жижиг, дунд үйлдвэрийн газарт:

1. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгож байгаа төслийн зээлийн санхүүжилтийг тухайн төсөл тус бүрийн хэрэгжүүлэх үе шатны хуваариар хэсэгчлэн олгох асуудлыг цаашид судлан, шийдвэрлэх нь зүйтэй байна.

---o0o---